



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

**ЦУВРАЛ 13**

Улаанбаатар, 2023

ННА 67  
ДАА 340  
Ш-978



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 13

СУДЛААЧИД:

Л.Эрдэнэхүү  
О.Билгүүн  
Д.Гүрдорж  
П.Намуун

Дугаар хариуцсан редактор Г.Оюунболд

© Нээлттэй нийгэм форум, 2023.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй нийгэм форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9083-0-0

# Шүүхийн шийдвэрийн судалгаа

## ЦУВРАЛ 13



# 1

ХҮН БАЙНГА АМЬДРАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ  
ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН БАЙР, ТУСГАЙЛАН ХАМГААЛСАН  
БАЙР, АГУУЛАХАД НЭВТЭРЧ ҮЙЛДСЭН ХУЛГАЙЛАХ  
ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГААНЫ  
ТАЙЛАН

9

# 2

ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИХ ГЭМТ  
ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙХ  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

73



## ӨМНӨХ ҮГ

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын 13 дугаарт эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт хийгдсэн хоёр судалгааны тайланг танилцуулж байна.

Хулгайн гэмт хэрэг эрүүгийн гэмт хэргийн хувьд хамгийн түгээмэл гардаг гэмт үйлдэл бөгөөд орон байранд нэвтэрч үйлдсэн хулгайн хэргийг шүүхээр ялгаатай шийдвэрлэж буй талаар Хууль дээдлэх ёс ТББ-ын судлаачдын хийсэн дүгнэлт анхаарал татаж байна.

Эрүүгийн хуульд 2015 онд шинээр хуульчлагдсан хууль бусаар мөрдөх, мөшгөх гэмт үйлдэл нь гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд анхаарах чухал асуудал болохыг судлаач П.Намуун хөндөхийн зэрэгцээ хууль бус мөрдөх, мөшгөх үйлдлийг таньж мэдэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, гэмт хэргийн хохирогч, үйлдэгч болохоос урьдчилан сэргийлэхэд тус дөхөм болох мэдлэг, мэдээллийг судалгааны тайландаа тусгажээ.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн үйл явц эрчимжихийн хэрээр түүнд хувь нэмэр оруулах шинэ залуу судлаачдын оролцоог дэмжих нь шүүхийн шийдвэр судалгааны төслийн нэг чухал зорилго бөгөөд залуу судлаачид энэхүү төсөлд идэвхтэй оролцох болсныг энэ дашрамд дурдахад таатай байна.

Энэ удаагийн дугаарыг эрхэлсэн, тайлангуудад шүүмж өгч ажилласан редактор, хуульч Г.Оюунболд болон нийт судлаач нартаа талархал илэрхийлж, цаашдын судлан шинжлэх үйлсэд нь амжилт хүсье. Уншигч Та манай [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас Шүүхийн шийдвэр судалгаа цувралын өмнөх дугаарууд болон холбогдох подкастуудыг хүлээн авах боломжтой бөгөөд санал шүүмжээ манай сошиал сувгуудаар дамжуулан ирүүлнэ үү.

ННФ-ын Гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал

## РЕДАКТОРЫН ҮГ

Энэ удаагийн цувралд “Хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” (ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалт) үйлдсэн хулгайн хэргийг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.12 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мөрдөж мөшгих” гэмт хэргийг шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийсэн залуу судлаачдын судалгааны тайлан багтаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт “нэвтэрсэн хулгай” гэж ярьж заншсан гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээнээс үзэхэд энэ гэмт хэргийг хоёр өөр янзаар шүүх шийдвэрлэж байгаа нь ажиглагдлаа. “Хууль дээдлэх ёс” ТББ-ын судлаачид нь тухайн гэмт хэргийн шинжийн талаар онолын болон практик асуудлыг хөндөж дээрх асуудлыг нээн илрүүлснээрээ ач холбогдол бүхий дүн шинжилгээ болжээ. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар зүйлийн 17.1-ийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтаар буюу нэвтэрсэн хулгайн гэмт хэргийг үйлдэх явцдаа газар дээрээ баригдсан, хууль бусаар бусдын өмчийг авах үйлдэл нь төгсөөгүй тохиолдолд хэрхэн зүйлчлэх талаар цагдаагийн алба хаагч, прокурор, шүүгчдийн хувьд өнөөг хүртэл маргаантай байгаа юм. Цаашид энэ гэмт хэргийг шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зайлшгүй шаардлага байгаа нь судалгаанаас харагдлаа.

Судлаач П.Намуун нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар зүйлийн 13.12-д заасан “Хууль бусаар мөрдөж мөшгих” гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ харьцуулсан судалгаа, хэргийн үйл явдалд анализ хийх,

ярилцлагын аргыг ашигласан нь ач холбогдолтой болсон байна. Судалгаагаар энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхдээ гэр бүлийн хамаарал бүхий хүнийг мөрдөн мөшгисөн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байгаа асуудлыг гаргаж ирсэн бөгөөд цаашид энэ талаар болон тухайн гэмт хэргийн тодорхойлолт, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн байна.

Түүнчлэн судлаачид хууль бусаар мөрдөн мөшгих гэмт хэргийг шийдвэрлэхдээ санаатай үйлдлийн шинж болох хүсэл зориг, сэдэлт зэргийг хэрхэн дүгнэж байгаа, субъектийн хувьд болон ял шийтгэлийн бодлогын талаар хөндсөн нь хууль хэрэглээний хувьд ач холбогдолтой мэдээлэл юм.

Тодорхой гэмт хэргийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар эрүүгийн эрх зүйн шинэ залуу судлаачид сонирхон судалж байгаа нь сайшаалтай явдал бөгөөд цаашид эрүүгийн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Редакцын зөвлөлийн гишүүн Г.Оюунболд



# 1

## ХҮН БАЙНГА АМЬДРАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН БАЙР, ТУСГАЙЛАН ХАМГААЛСАН БАЙР, АГУУЛАХАД НЭВТЭРЧ ҮЙЛДСЭН ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГАА  
ХИЙСЭН:  
ХУУЛЬ  
ДЭЭДЛЭХ ЁС  
ТББ

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### ЛХАГВАСҮРЭНГИЙН ЭРДЭНЭХҮҮ (L.M)

Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч Л.Эрдэнэхүү нь 2017 онд ИЗОУИС-ийн Их Засаг Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2021 онд мөн сургуульд хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр 2018-2021 онд Их Засаг хууль зүйн сургуулийн Захиргааны эрх зүйн тэнхимд багш, 2020-2021 онд мөн сургуулийн Клиник сургалтын төвд эрхлэгчээр тус тус ажилласан туршлагатай. Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшин судалгаа, шинжилгээ хийдэг бөгөөд 2021 оноос хойш, өнөөдрийг хүртэл хуульч, өмгөөлөгчөөр ажиллаж байна.



#### ОТГОНБААТАРЫН БИЛГҮҮН

“Хууль дээдлэх ёс” ТББ-ын гүйцэтгэх захирал, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч О.Билгүүн нь 2021 онд ИЗОУИС-ийн Их Засаг Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, одоогоор МУИС-ийн Хууль зүйн сургуульд магистрын зэрэг хамгаалахаар судалгаа хийж байна. Тэрээр 2021-2023 онд Өмгөөллийн “Монгол Өмгөөлөгч” ХХН-д эрх зүйчээр ажиллаж байсан бөгөөд эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг. 2022 онд “Хууль дээдлэх ёс” ТББ-ыг үүсгэн байгуулж, өнөөдрийг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



#### ДАШБАЗАРЫН ГҮРДОРЖ

Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Д.Гүрдорж нь 2021 онд ИЗОУИС-ийн Их Засаг Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Тэрээр 2021 оноос хойш, өнөөдрийг хүртэл Өмгөөллийн “Монгол Элч Консалтинг” ХХН-д хуульчаар ажиллаж байна.

Судлаачид:

Л.Эрдэнэхүү  
О.Билгүүн  
Д.Гүрдорж

## **АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	11
ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	12
УДИРТГАЛ.....	13
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....	17
1.1. Хулгайлах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал, тоон үзүүлэлт .....	17
ХОЁР. ГАДААД ОРНЫ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	32
2.1. ХБНГУ-ын Эрүүгийн эрх зүйн зохицуулалт .....	33
2.2. ОХУ-ын эрүүгийн эрх зүйн зохицуулалт.....	40
2.3. БНХАУ-ын эрүүгийн эрх зүйн зохицуулалт .....	42
ДҮГНЭЛТ .....	44
ЗӨВЛӨМЖ.....	48
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ .....	49

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШШШ	Анхан шатны шүүхийн шийдвэр
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БАДСДЭХАШШ	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
БЗДЭХАШШ	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ГХ	Гэмт хэрэг
ДЗШШШ	Давж заалдах шатны шүүхийн шийдвэр
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУТ	Олон улсын гэрээ
ОХУ	Оросын Холбооны Улс
СБДЭХАШШ	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
СХДЭХАШШ	Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
УДШ	Улсын Дээд шүүх
ХУДЭХАШШ	Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЧДЭХАШШ	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги

## **ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

График 1. Хулгайлах гэмт хэргийн статистик .....	17
Хүснэгт 1. Шүүхийн шийдвэрүүд .....	14
Хүснэгт 2. Ойролцоо тохиолдол бүхий гэмт хэргийг шийдвэрлэсэн байдал.....	30

## УДИРТГАЛ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Хулгайлах гэмт хэрэг (ГХ) нь жил бүр Монгол Улсад бүртгэгддэг нийт гэмт хэргийн гуч орчим хувийг тогтмол эзэлдэг, түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг юм. Энэхүү гэмт хэргийг “Хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” (ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалт) үйлдсэн нөхцөлд шүүхээс шийдвэрлэж буй шүүхийн практик харилцан адилгүй байгаа нь тусгайлан судлах үндэслэл болов.

Хулгайлах гэмт хэргийн зүйлчлэл, хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг арилгах, тэдгээрийн нэгдсэн ойлголтыг хэрхэн тайлбарлаж, хэрэглэж буйг тогтооход энэхүү судалгааны ажлын зорилго оршино. ЭХТА-ийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад “энэ гэмт хэргийг “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч,” үйлдсэн бол...” гэж хуульчилжээ. Үүнээс үзэхэд бусдын орон байранд нэвтэрснээр ГХ-ийг шууд төгсгөх буюу үндсэн нөхцөлийг хангахгүйгээр төгсгөж зүйлчилсэн байна. Өөрөөр хэлбэл, хулгайлах ГХ-ийн үндсэн шинжид бусдын эд хөрөнгийг авсан буюу өөрийн өмчийн адил эзэмших, ашиглах, захиран зарцуулах бодит боломж бий болсноор төгссөн гэмт хэрэг гэж үзэхээр зохицуулжээ. Үүнээс үзэхэд бусдын орон байранд нэвтэрснээр ГХ-ийг шууд төгсгөх

буюу үндсэн нөхцөлийг хангахгүйгээр төгсгөж зүйлчилсэн байна. Энэ нь Эрүүгийн эрх зүйн онолын хувьд маргаантай, эцэслэн шийдвэрлэгдээгүй асуудал юм. Иймд энэ гэмт хэргийн “орон байранд нэвтэрсэн” гэсэн хүндрүүлэх шинж нь хууль хэрэглэх онол, зарчим, түүнчлэн Эрүүгийн хууль хэрэглээний түүхэн уламжлал, чиг хандлагад нийцэж буй байдлыг судлах шаардлагатай гэж үзсэн болно.

Судалгааны ажлыг ерөнхий арга зүйн хувьд тоон болон чанарын судалгааны аргад тулгуурлаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс боловсруулсан 2015 оны “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн болно.

Тус судалгаагаар 2018 оны 01 дүгээр сараас 2023 оны 01 дүгээр сар хүртэлх Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтаар зүйлчлэн шийдвэрлэгдсэн хуулийн хүчин төгөлдөр 827 шүүхийн шийдвэр судлагдсан бөгөөд үүнээс ижил тохиолдол бүхий 23 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээс арван шүүхийн шийдвэрийг сонгон түүвэрлэснийг доор орууллаа. Эдгээрээс таван тохиолдолд шүүхээс гэмт хэргийг төгссөн, таван тохиолдолд гэмт хэргийг төгсөөгүй буюу үйлдэхээр завдсанд тооцож шийдвэрлэжээ. Үүнд:

Хүснэгт 1. Шүүхийн шийдвэрүүд

№	Судалсан хэрэг	Анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн	Давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэсэн	Хяналтын шатны шүүхээс шийдвэрлэсэн
1	Сэлэнгэ аймгийн хэрэг (гэмт хэрэг төгссөн)	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар шийтгэх тогтоол	Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар магадлал	Монгол Улсын Дээд шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 214 дүгээр тогтоол

2	Сонгинохайрхан дүүргийн хэрэг (гэмт хэрэг үйлдэхээр завдсан)	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 717 дугаар шийтгэх тогтоол		
3	Орхон аймгийн хэрэг (гэмт хэрэг үйлдэхээр завдсан)	Орхон аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 71 дүгээр шийтгэх тогтоол	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 22 дугаар магадлал	
4	Сонгинохайрхан дүүргийн хэрэг (гэмт хэрэг үйлдэхээр завдсан)	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 887 дугаар шийтгэх тогтоол		
5	Баянзүрх дүүргийн хэрэг (гэмт хэрэг үйлдэхээр завдсан)	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1365 дугаар шийтгэх тогтоол		
6	Сонгинохайрхан дүүргийн хэрэг (гэмт хэрэг үйлдэхээр завдсан)	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 927 дугаар шийтгэх тогтоол		

7	Сүхбаатар дүүргийн хэрэг (гэмт хэрэг төгссөн)	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 643 дугаар шийтгэх тогтоол		
8	Баянзүрх дүүргийн хэрэг (гэмт хэрэг төгссөн)	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 862 дугаар шийтгэх тогтоол		
9	Сүхбаатар дүүргийн хэрэг (гэмт хэрэг төгссөн)	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 770 дугаар шийтгэх тогтоол		
10	Сүхбаатар дүүргийн хэрэг (гэмт хэрэг төгссөн)	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 250 дугаар шийтгэх тогтоол		



## НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 1.1. ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Сүүлийн таван жилийн статистикаас үзэхэд Монгол Улсад жилд дунджаар 29,699 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 8858 нь хулгайлах гэмт хэрэг байна. Үүнээс үзвэл хулгайлах гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 29.8 хувийг дангаараа эзэлж буй юм. Мөн энэ төрлийн гэмт хэргийн сүүлийн таван жилд шүүхээр шийдвэрлэгдсэн байдлыг үзвэл:

График 1. Хулгайлах гэмт хэргийн статистик



Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг:” гээд тус хэсгийн 2.1-д “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” гэж заасан ба үүний “... нэвтэрч” буюу байр, агуулахад нэвтэрснээр энэхүү гэмт хэрэг (ЭХТА-ийн 17.1.2.1) төгссөнд тооцохоор хууль тогтоогч хуульчилсан нь онолын хувьд болон практикт маргаантай асуудал хэвээр байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн үндсэн шинжид (ЭХТА-ийн 17.1.1) “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол...” гэж заасан ба үүний “...авсан бол” гэдэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч өөртөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломж бий болгох, захиран зарцуулсан байхыг ойлгодог.<sup>1</sup> Гэтэл бусдын орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад зөвхөн нэвтэрснээр тухайн гэмт хэрэг төгссөнд тооцож, хөрөнгө захиран зарцуулах боломж үүссэн талаар дүгнэх эсэх нь эргэлзээтэй.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын үүднээс авч үзвэл аливаа гэмт хэргийн хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал бүр бие даасан шинж чанартай ба гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжийг шаарддаг. Үүнээс үзвэл аливаа гэмт хэргийн үндсэн шинжийг хангахгүйгээр хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинжийг тусгайлан үнэлж, зүйлчлэх боломжгүй юм.

<sup>1</sup> Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 28 дугаар тогтоол:

1. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг дор дурдсанаар тайлбарласугай:  
1.1. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэдэгт бусдын эд хөрөнгийг нууц, далд аргаар, шунахай сэдэлтээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авч, бүрмөсөн, үнэ төлбөргүй өөрийн өмчийн адил захиран зарцуулах боломж бүрдүүлсэн буюу захиран зарцуулсан шууд санаатай үйлдлийг ойлгоно.

## Шүүхийн шийдвэр 1 (Гэмт хэрэг төгссөн)

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>2</sup>, Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал<sup>3</sup>, Улсын Дээд шүүхийн тогтоол<sup>4</sup>

### Хэргийн товч агуулга:

Шүүгдэгч Г.О нь 2019 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр баг, Алтан плаза төвийн хоёр давхарт байрлах менежерийн өрөөг хутгаар онгойлгон орж хохирогч М-ийн жижиг цүнхнээс 3900 рубль буюу 164,000 төгрөгийг бэлнээр авч, хувцас солих өрөөнд тоолж байхад нь гэрч Э харсан ба тэр дор нь цүнх болон мөнгийг буцаан авсан үйлдэл.

### Хэргийг шийдвэрлэсэн байдал:

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан “...*цйл ажиллагаа явуулах зориулалттай орон байранд хууль бусаар нэвтэрч хулгайлах*” гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж дүгнэн, “*Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар шүүгдэгч Боржигон овогт Г.О-ийг нэг жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй*” хэмээн шийдвэрлэсэн.

<sup>2</sup> Г.О-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар шийтгэх тогтоол.

<sup>3</sup> Г.О-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар магадлал.

<sup>4</sup> Г.О-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Улсын Дээд шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 214 дүгээр тогтоол.

### **Давж заалдах шатны шүүхийн магадлал:**

Сэлэнгэ аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх дээрх хэргийг хууль бусаар нэвтрэн орж шургуулгаас 3900 рубль хулгайлсан боловч өөрийн эзэмшилд оруулж, захиран зарцуулж амжилгүйгээр түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэргийг төгсгөж чадаагүй, түүнийг хулгайлах гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэж үзэн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “...хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан “...үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байранд хууль бусаар нэвтэрч хулгайлах” гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэм буруутайд тооцсугай” гэж, 2 дахь заалтыг “...Эрцүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар шүцгдэгч Г.О-г нэг жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй” гэж өөрчлөн найруулж, шийтгэх тогтоолын бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

### **Улсын Дээд шүүхийн тогтоол:**

Улсын Дээд шүүх эл хэргийг “...Эрцүгийн хуулийн тусгай ангид заасан хулгайлах гэмт хэрэг нь хууль ёсны өмчлөгчийн эзэмшлээс түүний эд зүйлийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар өөрийн эзэмшилд шилжүүлэн авснаар төгсдөг бөгөөд уг эд хөрөнгийг захиран зарцуулах, хувиргах, хууль ёсны эргэлтэд оруулах нь өөр гэмт хэргийн шинжид хамаарах боломжтой юм...” хэмээн дүгнэж, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгон шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэр 2 (Гэмт хэрэг үйлдэхээр завдсан)**

Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>5</sup>

<sup>5</sup> Д.Т-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 717 дугаар шийтгэх тогтоол.

**Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Д.Т нь 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 7 дугаар хороо, Намгийн 1 дүгээр гудамжны \*\* тоотод иргэн К.Ч-ийн эзэмшлийн монгол гэрийн цоожны даруулга төмрийг хөшиж, хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтрэн, бусдын эд хөрөнгө болох 32 инчийн LG маркийн зурагт, зурагтын удирдлага, нокиа маркийн гар утас зэрэг (310,000 төгрөгийн үнэ бүхий)-ийг авч гэрээс гарч байхад (хашаанд) гэрч Г болон Х нар барьж авсан үйлдэл.

**Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх *“хэрэгт цугларсан нотлох баримтаар шүүгдэгч нь хэрэг учралын газарт буюу тухайн хохирогчийн гэрийн хашаанд тэр даруйд гэмт үйлдэл нь таслан зогсоогдсон байх бөгөөд хулгайлсан эд хөрөнгийг захиран зарцуулах бодит боломж төгс бүрдээгүй байх тул хулгайлах гэмт хэрэгт завдсан гэж үзэх үндэслэлтэй”* хэмээн дүгнэн, *“Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар шүүгдэгч Д.Т-ыг нэг жил нэг сарын хугацаагаар хорих ялаар шийтгэсүгэй”* хэмээн шийдвэрлэжээ.

**Дүн шинжилгээ**

Дээрх хоёр хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээс үзэхэд шүүх захиран зарцуулах бодит боломж бүрдээгүй ижил тохиолдлуудад эсрэг агуулгатай дүгнэлт хийжээ. Эхний тохиолдолд бусдын эд хөрөнгийг өөрийн эзэмшилд авснаар гэмт хэрэг төгсөх бөгөөд захиран зарцуулах нь өөр гэмт хэргийн шинжид хамаарах боломжтой хэмээн гэмт хэргийг төгссөн гэж дүгнэсэн бол дараагийн тохиолдолд хулгайлсан эд хөрөнгийг захиран зарцуулах бодит боломж төгс бүрдээгүй хэмээн “орон байранд нэвтэрч хулгайлах”

гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэж дүгнэн шийдвэрлэжээ. Эдгээртэй адил тохиолдолд шүүхээс харилцан адилгүй, эсрэг дүгнэлт хийн, хэргийг шийдвэрлэж буй нь тодорхой харагдаж байна.

### **Шүүхийн шийдвэр 3 (Гэмт хэрэг үйлдэхээр завдсан)**

Орхон аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>6</sup>, Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал<sup>7</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч С.О, А.Г нар нь бүлэглэн 2020 оны 10 дугаар сарын 31-ний 23 цагийн орчимд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Цагаанчулуут баг “Эко” хорооллын 121-15 тоот байшингийн цонхоор хууль бусаар нэвтрэн орж, шатны доод талын хаалгыг онгойлгоод эд зүйл ухаж байхад нь гэрч Б болон М нар барьж авсан үйлдэл.

#### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Орхон аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгчийн гэмт хэргийг төгсгөж чадаагүй нөхцөл байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзэх үндэслэлтэй хэмээн дүгнэж, “*Шүүгдэгч А.Г, С.О нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар бэлэглэж хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч хулгайлахыг завдсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай*”, “*Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д*

<sup>6</sup> С.О, А.Г нарт холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Орхон аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 71 дүгээр шийтгэх тогтоол.

<sup>7</sup> С.О, А.Г нарт холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 22 дугаар магадлал.

зааснаар шүүгдэгч А.Г-г хоёр жил есөн сарын хугацаагаар, С.О-г гурван жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсүгэй” хэмээн шийдвэрлэжээ.

#### **Давж заалдах шатны шүүхийн магадлал:**

Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх “Анхан шатны шүүх шүүгдэгч С.О, А.Г нарын гэм буруугийн асуудлыг хэлэлцээд 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч хулгайлахыг завдсан гэмт хэрэг үйлдсэн талаар хууль зүйн дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэжээ”, харин “хулгайлахыг завдсан гэмт хэрэг үйлдсэн байхад анхан шатны шүүх төгссөн гэмт хэрэгт оногдуулсан ялын хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний хорих ялаар шийтгэсэн нь тэдний үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдалд тохироогүй байна” хэмээн дүгнэж хорих ялыг тус бүр хоёр жилийн хорих ял болгон хөнгөрүүлж, бусад заалтыг хэвээр үлдээн шийдвэрлэжээ.

#### **Шүүхийн шийдвэр 4 (Гэмт хэрэг үйлдэхээр завдсан)**

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>8</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Т.А нь 2021 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 14 цагийн үед Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хороо, Баруун баян уулын 13-52 тоотод оршин суух иргэн С.Г-ийн байшингийн цонхоор хууль бусаар нэвтэрч, 32 инчийн ТСЛ загварын зурагтыг (480,000 төгрөгийн үнэ бүхий) авч гэрээс гарах үед хохирогч С.Г хашааны үүдэнд ирсний улмаас зурагтыг орхин зугтсан үйлдэл.

<sup>8</sup> Т.А-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 887 дугаар шийтгэх тогтоол.

### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх “шүүгдэгч нь бусдын эд хөрөнгийг хулгайлан авч гарах явцдаа хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас хулгайлах гэмт хэргээ туйлдаа хүргээгүй буюу эд зүйлсийг захиран зарцуулах бодит боломж бий болоогүй, тухайн зурагтаа хашаанд үлдээж, зугтаасан үйлдэл нь хулгайлах гэмт хэрэг төгссөн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул тухайн гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэм буруутайд тооцох хууль зүйн үндэслэлтэй” хэмээн дүгнэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д заасан “хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч хулгайлахыг завдсан гэмт хэрэг үйлдсэн” гэм буруутайд тооцож, хоёр жил таван сарын хугацаагаар хорих ял оногдуулан шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэр 5 (Гэмт хэрэг үйлдэхээр завдсан)**

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>9</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Я.М нь 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо 81 дүгээр байрны 48 тоотод оршин суух иргэн Ц.Б-ын гэрт буюу хүн байнга амьдрах орон байранд хууль бусаар түлхүүр тааруулан нэвтэрч, Асер маркийн 520,000 төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютерыг авч байхад нь гэрч Б.Б хажуу өрөөнөөс гарч ирж зогсоосон үйлдэл.

<sup>9</sup> Я.М-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1365 дугаар шийтгэх тогтоол.



**Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэргийг үйлдэхээр завдсан, мөн завдсан нөхцөл байдал, хор уришгийн шинж чанар их биш, хэр хэмжээ бага” хэмээн дүгнэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгүүдэд заасныг тус тус журамлан, мөн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар зургаан сар хорих ял оногдуулан шийдвэрлэжээ.

**Шүүхийн шийдвэр 6 (Гэмт хэрэг үйлдэхээр завдсан)**

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>10</sup>

**Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Н.Н нь 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт оршин суух иргэн Б-ийн монгол гэрийн хаалганы цоожны төмөр арлыг хөшиж, дотогш нэвтрэн 280,000 төгрөгийн үнэ бүхий Toshiba маркийн зурагтыг аваад гэрийн хаалгаар гарахад гэрч О барьж авсан.

**Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх “шүүгдэгч нь хүн байнга амьдрах зориулалттай орон сууцанд нэвтэрч эд зүйлийг авсан үйлдэл хийсэн боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдал буюу гэрч О гэрийн гадна ирсний улмаас гэмт хэрэг төгсөөгүй болох нь тогтоогдож байх тул гэмт хэрэг үйлдэхээр завдсан гэж үзэх үндэслэлтэй байна. Хулгайлах гэмт хэргийг гэмт этгээд хулгайлсан эд хөрөнгийг эзэмшилдээ авах, өөрийн болгон захиран зарцуулах

<sup>10</sup> Н.Н-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 927 дугаар шийтгэх тогтоол.

бодит бололцоо бий болсон цеэс төгссөнд тооцох бөгөөд шүүгдэгч тухайн эд хөрөнгийг хадгалан хамгаалагдаж байсан орон зайнаас буюу монгол гэрээс хөдөлгөж шилжүүлсэн (гэрийн гадна гаргаж тавьсан) боловч өөрийн болгон хэрэглэх бодит боломж бүрдээгүй байсан тул хулгайн хэрэг төгссөнд тооцох үндэслэлгүй” хэмээн дүгнэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад заасан Хулгайлах гэмт хэргийг хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч үйлдэхийг завдсан гэм буруутайд тооцож, зургаан сарын хугацаагаар хорих ял оногдуулан шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэр 7 (Гэмт хэрэг төгссөн)**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>11</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Д.Г нь 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Хангайн 23-66 тоотод оршин суух иргэн Э.Э-ийн байшингийн хаалганы цоожийг эвдлэн нууцаар, хууль бусаар нэвтрэн орж нийт 203,200 төгрөгийн үнэ бүхий эд зүйл авч гарах гэж байхад нь гэрч болон хохирогч нар гэрт орж ирэн барьсан үйлдэл.

#### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх “...Эрцүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан байх тул түүнийг дээрх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрцүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй...” хэмээн дүгнэж, Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгийг журамлан нэг жилийн хорих ял оногдуулан шийдвэрлэжээ.

<sup>11</sup> Д.Г-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 643 дугаар шийтгэх тогтоол.

### **Шүүхийн шийдвэр 8 (Гэмт хэрэг төгссөн)**

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>12</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Н.Н нь 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдөр Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, Консулын тоотод байрлах иргэн А.Д-ийн гэрийн тооноор орж тавиурын шургуулгаас бэлэн 300,000 төгрөгийг авч гэрийн тооноор буцаж гарах үед нь хохирогч А.Д барьж авсан үйлдэл.

#### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгчийг бусдын эд хөрөнгийг нууцаар, хууль бусаар орон байранд нэвтэрч хулгайлсан гэмт хэрэг үйлдсэнд тооцож, хоёр жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэр 9 (Гэмт хэрэг төгссөн)**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>13</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Х.Т нь 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлах иргэн Д.А-ийн тусгайлан хамгаалсан байр буюу амбаарт нэвтрэн 524,400 төгрөгийн эд зүйлийг авч гарч байхад нь хохирогч Д.А барьсан үйлдэл.

#### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгчийн үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...*Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг*

<sup>12</sup> Н.Н-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 862 дугаар шийтгэх тогтоол.

<sup>13</sup> Х.Т-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 770 дугаар шийтгэх тогтоол.

*хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно...*” гэж заасантай нийцсэн, хулгайлах гэмт хэргийн үндсэн шинжийг бүрэн хангаж байна, мөн тусгайлан хамгаалсан объект болох хашаа, амбаарт хууль бусаар нэвтэрч хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тул хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг мөн хангажээ хэмээн дүгнэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, нэг жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар шийдвэрлэжээ.

### **Шүүхийн шийдвэр 10 (Гэмт хэрэг төгссөн)**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол<sup>14</sup>

#### **Хэргийн товч агуулга:**

Шүүгдэгч Б.Б нь 2020 оны 10 дугаар сарын 12-ны шөнө 02 цагийн үед Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутагт байрлах Хангай хотхоны 505 дугаар байрны В-1 давхрын өрөөний цонхоор орж 600,000 төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг авч байх үед нь гэрч Г харж барьсан үйлдэл.

#### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх *“шүүгдэгч Б.Б нь дээр дурдсанчлан нууц далд аргаар, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байранд нэвтэрч, бусдын өмчлөх эрхэд хууль бусаар халдан гагнуурын аппарат, дрилл, тастагч зэрэг багажийг өөр газарт зөөвөрлөн аваачин нууж өөрийн эзэмшилд авч тэдгээрийг захиран зарцуулах бодит боломжийг өөрт буй болгосон нь хулгайлах гэмт хэрэг төгс үйлдэгдсэнийг илтгэнэ. Харин гагнуурын аппарат, дрилл, тастагч зэрэг багаж хулгайлагдсан байхад сүүлд молдок (бетон*

<sup>14</sup> Б.Б-д холбогдох Хулгайлах гэмт хэргийн тухай Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 250 дугаар шийтгэх тогтоол.

цутгамал эвдэгч) багажийг авч гарах гэж байгаад амжаагүй баригдсан нь тусдаа үйлдэл, эсхүл ерөөс бүх эд зүйлийг хулгайлахаар завдсан мэтээр дүгнэх боломжгүй” хэмээн дүгнэж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, хоёр жилийн хугацаагаар хорих ял оногдуулахаар шийдвэрлэжээ.

### **Дүн шинжилгээ**

Дээрх шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд шүүх гэмт хэргийг төгсөөгүй буюу завдсан гэж үзэн хэргийг зүйлчлэх, мөн тайлбарлахдаа гол төлөв шүүгдэгчийн бусдын эд хөрөнгийг өөрийн болгож хэрэглэх, ашиглах болон захиран зарцуулах бодит боломж бүрдсэн эсэхэд хууль зүйн дүгнэлт өгчээ.

Шүүхээс энэ төрлийн гэмт хэргийг төгссөн гэж зүйлчилж, шийдвэрлэхдээ орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрснээр, эсхүл нэвтэрч эд хөрөнгийг эзэмшсэнээр гэмт хэрэг төгссөн хэмээн шууд ойлгож хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, захиран зарцуулах бодит боломж бий болсон эсэх болон үйлдлийн шинж чанарт нь ач холбогдол өгөлгүйгээр гагцхүү гэмт этгээдийн хүсэл зориг, гэмт хэргийг үйлдэх санаа сэдлээр нь дүгнэн, тайлбарлаж байна.

Харин зарим тохиолдол (Шүүхийн шийдвэр 10)-д гэмт хэргийг төгссөн хэмээн зүйлчлэхдээ шүүгдэгчийг зарим эд хөрөнгийн хувьд захиран зарцуулах бодит бололцоог өөрт бий болгосон, ингэхдээ дараагийн эд хөрөнгийг үргэлжлүүлэн хулгайлах буюу гэмт хэрэг үргэлжилж байх нөхцөлд таслан зогсоогдсон нь өмнөх эд хөрөнгийн хувьд төгссөн, дараагийн эд хөрөнгийн хувьд завдсан гэж үзэхгүй хэмээн бүх эд хөрөнгийн хувьд тухайн гэмт хэргийг төгссөн хэмээн хууль зүйн дүгнэлт гаргаж, шийдвэрлэжээ.

Мөн дээрх шийдвэрүүдэд хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан шүүх харилцан адилгүй хэмжээгээр хорих ял оногдуулсан боловч

гэмт хэргийг завдсан хэмээн дүгнэж, шийдвэрлэсэн тохиолдолд оногдуулсан хорих ялын хэмжээ харьцангуй ижил буй юм. Тухайлбал, гэмт хэргийг завдсан хэмээн дүгнэж, шийдвэрлэсэн Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 927 дугаар шийтгэх тогтоол, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1365 дугаар шийтгэх тогтоолуудад тус бүр зургаан сарын хугацаатай хорих ял оногдуулж буй нь Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчим, уг гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын ойлголтыг тайлбарлаж, хэрэглэх замаар тогтсон шүүхийн практик болохыг харуулж байна.

Хүснэгт 2. Ойролцоо тохиолдол бүхий гэмтхэргийг шийдвэрлэсэн байдал

Гэмт хэрэг төгссөн	Оногдуулсан ял	Гэмт хэрэг үйлдэхээр завдсан	Оногдуулсан ял
Монгол Улсын Дээд шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 214 дүгээр тогтоол	Нэг жил хорих ял	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 717 дугаар шийтгэх тогтоол	Нэг жил нэг сар хорих ял
Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 250 дугаар шийтгэх тогтоол	Хоёр жил хорих ял	Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 22 дугаар магадлал	Хоёр жил хорих ял
Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 643 дугаар шийтгэх тогтоол	Нэг жил хорих ял	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 887 дугаар шийтгэх тогтоол	Хоёр жил таван сар хорих ял

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 862 дугаар шийтгэх тогтоол	Хоёр жил хорих ял	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 927 дугаар шийтгэх тогтоол	Зургаан сар хорих ял
Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 770 дугаар шийтгэх тогтоол	Нэг жил хорих ял	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 1365 дугаар шийтгэх тогтоол	Зургаан сар хорих ял

Дээрх 2019-2021 оны шүүхийн шийдвэрүүдээс орон нутгийн болон шат шатны шүүх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж байсан нь харагдаж байна. Энэ нь Эрүүгийн хуульд заасан “нэвтэрсэн хулгайн” гэмт хэргийг зүйлчлэх хууль хэрэглээний болон шүүхийн практик тогтоогүй болохыг илтгэж буй юм. Мөн Монгол Улсын Дээд шүүхийн 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 214 дүгээр тогтоол, түүний үндэслэл нь энэ гэмт хэргийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход жишиг болохуйц хэмжээнд хүрээгүй гэж үзэж байна.

## ХОЁР. ГАДААД ОРНЫ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эрүүгийн эрх зүй нь хүний эрхийн үнэт зүйлсийг хамгаалахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж буйгаараа өнөө үед Үндсэн хуулийн эрх зүйн түвшинд зэрэгцэн үнэлэгдэх эрх зүйн тулгуур салбар болон хөгжиж байна.

Монгол Улс нь төрт ёс, хууль цаазын арвин баялаг уламжлалтай (817 жил) боловч анхны төрөлжсөн Эрүүгийн хуулийг 1926 онд баталсан билээ. 1926 оны анхны Эрүүгийн хуулиас хойш эдүгээ хүртэл нийт найман удаа Эрүүгийн хуулийг шинэчлэн баталжээ (1926, 1934, 1942, 1960, 1987, 1994, 2002, 2015).

1990-ээд оноос хойш дэлхийн олон улс орон эрүүгийн эрх зүйн салбарт реформ хийж, үр дүнд хүрсэн бөгөөд ялангуяа ялын бодлогод хүмүүнлэгийн хандлага хүчтэй илрэх болж, цаазаар авах болон хорих ялыг илт хязгаарлах болсон юм.<sup>15</sup> Түүнчлэн эрүүгийн эрх зүйн болон ялын бодлогод хүний халдашгүй эрх, эрх зүйт ёсны шаардлагыг хангахад чиглэгдсэн НҮБ-ын гэрээ, конвенц цөөнгүй гарсныг дурдах нь зүйтэй. Үүний зэрэгцээ шилжилтийн болон зөрчилдөөний дараах үеийг туулж буй орнуудад зориулж НҮБ-ын санаачилга, дэмжлэгтэйгээр 2007 онд Дэлхийн эрүүгийн загвар хуулийг<sup>16</sup> гаргасан нь хөгжиж буй орнууд эрүүгийн хууль тогтоомждоо шинэчлэлт, өөрчлөлт хийхэд чухал түлхэц болж буй юм.

<sup>15</sup> Д.Баярсайхан, Монголын эрүүгийн эрх зүйн шинэтгэл, үр дүн, хэтийн төлөв, Монгол-Герман харьцуулсан ЭЗЗ-ийн эрдэм шинжилгээний илтгэлүүд, 2018, 88 дахь тал.

<sup>16</sup> Model Codes for Post-conflict, Criminal Justice Model Criminal Code, Vivienne O'Connor and Colette Rausch editors, Peasbuilding and the Rule of law. WPL, 2007 /usip.org/.



Тийм ч утгаараа Монгол Улс 2015 оны Эрүүгийн хуульдаа хүний эрхийн үнэт зүйлс, суурь зарчим, орчин үеийн эрүүгийн эрх зүйн жишиг, түгээмэл хандлагыг тусгаж, Дэлхийн эрүүгийн загвар хууль болон Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан Олон улсын гэрээ, конвенцод<sup>17</sup> нийцсэн үзэл баримтлалыг суулгаж чадсан билээ.

## 2.1. ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Германы эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь эрх зүйт төрийн шаардлагыг хангадаг бүтэц юм. Өөрөөр хэлбэл, тус улсын “Ерөнхий анги” хэмээх эрүүгийн эрх зүйн догма нь XIX зуунаас эхлэн хөгжсөн буюу нэр томьёо, ойлголтуудыг цэгцэлж, хооронд нь ялгаж өгсөн байдаг. Иймд ямар ч гэмт хэргийг нэг тодорхой шалгах тогтолцооны дагуу задлан шинжилж, үнэлж дүгнэдэг. Ингэснээр эрх зүйг хэрэглэхэд алдаа, дутагдал гарах боломж үгүй болж, эрх зүйт төрийн зарчимд нийцдэг. Ийнхүү тодорхой бүтэц гаргаж өгсөн тогтолцоог нарийн ажиглавал дараах дөрвөн давуу талыг олж харж болно.<sup>18</sup> Үүнд:

1. Аливаа гэмт хэрэгт шийтгэл оноохдоо дур зоргоор тогтоохгүй, хуульчилсан гэмт хэргийн бүрэлдэхүүнд үндэслэн, урьдчилан тогтоосон бүтцийн дагуу шалгаж, тогтоодог тул тодорхой бүтэц, тогтолцоотой эрүүгийн эрх зүй нь ил тод бөгөөд ойлгоход хялбар байдаг.
2. Тодорхой бүтэц тогтолцоо бүхий эрүүгийн эрх зүйтэй улсын эрүүгийн шүүхийн шийдвэрүүдийг хянах, шалгах боломж бүрддэг. Дээд шатны шүүхээс гадна эрүүгийн эрх зүйн судлаачид, олон нийт зэрэг хараат бус субъект ч эрүүгийн

<sup>17</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын ЕА-н 217/А/III/ тогтоол, 1946. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, НҮБ-ын ЕА-н 2200А(XXI) 1966-1976, 1968-1974

<sup>18</sup> Эрик Хилгенфорд, Эрүүгийн эрх зүй дэх зүй тогтолцоо, Хилгендорфын эрхлэн гаргасан Хятад, Германы эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудлаас, 2015, 37-51 дахь тал.

шийдвэр, тогтоолтой танилцаж, хянаж, шаардлагатай нөхцөлд шүүмжлэх боломжтой байдаг.

3. Иргэд нь төр ямар үйлдэл, эс үйлдэхүйг хориглосон, ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцдог талаар мэдлэгтэй байдаг. Энэ нь эрх зүйн аюулгүй байдлын нэн чухал шаардлага бөгөөд үүнгүйгээр орчин үеийн, эрх зүйт төрийн үндсэн зарчимд тулгуурласан нийгэм оршин тогтнох боломжгүй юм.
4. Тодорхой бүтэц тогтолцоо бүхий эрүүгийн эрх зүйн дөрөв дэх давуу тал нь түүнийг заах, сургах тал дээр илэрнэ. Хэрэг тус бүрийг цээжилж, тэдэн дундаас уялдаа холбоо гаргаж ирэхийг хичээхийн оронд Германы эрүүгийн хууль тогтоомж нь маш ойлгомжтой томъёологдсон тул шинэ хэрэг дээр тууштай хэрэглэгдэж болох давуу талтай. Энэ дидактик давуу тал нь Германы эрүүгийн гэмт хэргийн тогтолцоо өргөн тархахад чухал нөлөө үзүүлсэн байдаг.

Тоймлон хэлэхэд, Германы эрүүгийн эрх зүйн давуу тал нь гэмт хэрэг бүрийг тодорхойлсон тусгай ангид бус харин гэмт хэргийн бүтэц, тогтолцоо, эрүүгийн эрх зүйн үндсэн ойлголт, тэдгээрийн нэр томъёоны уялдаа холбоо, бүх гэмт хэрэгт хамаатай ерөнхий зохицуулалт зэргийг агуулсан Ерөнхий ангид оршдог аж.

Үүний зэрэгцээ Германд эрүүгийн гэмт хэргийн онолын үзэл баримтлалын гурван тулгуурт тогтолцоонд шилжих хандлага хөгжжээ. Монгол Улс энэ тогтолцоонд тулгуурладаг олон орны нэг болсноор олон улсын эрүүгийн эрх зүйн догмаг баримтлагч орон болж буй юм. Эрх зүйн салбарт хамтран ажиллах олон улсын хамтын ажиллагаанд тавигдах нэгэн чухал шаардлага бол оролцогчид ижил түвшинд харилцах явдал юм. Улс орон бүрийн онцгой нөхцөл байдлаас үл хамааран хүн бүрийн эрх, ашиг сонирхлын үүднээс Герман Улсын эрүүгийн эрх зүйн зарчим нь олон улсын хувьд эрүүгийн эрх зүйг хүнлэг болгоход чухал хувь

нэмэр оруулжээ.<sup>19</sup>

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд эрүүгийн эрх зүйн зарчмуудыг жагсааж бичдэггүй. Германы эрүүгийн эрх зүйн зарчмыг ХБНГУ-ын 1949 оны Үндсэн хуульд “Хуульгүйгээр ял гэж үгүй” хэмээн тусгасан байдаг. Энэхүү зарчмыг ХБНГУ-ын Үндсэн хуулийн 103 дугаар зүйлийн 3 дахь заалт болон ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлд “Тухайн үйлдэл/эс үйлдэхүй хийгдэхээс өмнө хуулиар ял хүлээлгэхээр тогтоосон нөхцөлд л ял оногдуулна” гэж заажээ. Иймд ХБНГУ-д ялыг зөвхөн бичмэл эрх зүйн хэм хэмжээнд үндэслэн оногдуулах бөгөөд хэм хэмжээг төсөөтэй хэрэглэхийг хориглодог.

**Гэм буруугийн зарчим** - Энэ зарчмын үндсэн дээр тухайн этгээдийн гэм буруутай үйлдэл/эс үйлдэхүйд ял оногдуулна. Холбооны Үндсэн хуулийн шүүх “гэм бурууг тогтоолгүйгээр ял оногдуулах нь эрх зүйт төрийн зарчимд харшилна” гэж үзжээ. ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэм буруу нь яллах үндэслэл болно. Уг зүйлийн 2 дахь заалтад дурдагдсан бусад нөхцөл байдал (сэдэлт, зорилго, үзэл бодол, хүсэл зориг гэх мэт) ялын хэмжээг тодорхойлоход туслах чанарын ач холбогдолтой.

**Гэмт хэрэг** - Гэмт хэрэг бол материаллаг эрүүгийн эрх зүйн ойлголт юм. Процессын утгаар гол төлөв үйл гэж хэрэглэгддэг.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн (12 дугаар зүйл) дагуу гэмт үйлийг гэмт хэрэг болон зөрчил гэсэн хоёр төрөлд хуваана. Ийнхүү ангилахдаа хэлбэрийн шинж болох ялын доод хэмжээг шалгуур болгожээ. Гэмт хэрэг гэдэг нь нэгээс доошгүй жил хорих ял оногдуулахаар заасан хууль бус үйл, харин зөрчил гэдэг нь үүнээс бага хугацаагаар хорих буюу мөнгөн торгуультай хууль бус үйл юм.

<sup>19</sup> Эрик Хилгендорф, Монголын эрүүгийн эрх зүйн шинэтгэл, үр дүн, хэтийн төлөв, Монгол-Герман харьцуулсан ЭЭЗ-н эрдэм шинжилгээний илтгэлүүд, УБ., 2018, 99-105 дахь тал.

**Завдах** – Германы эрүүгийн эрх зүйн онол болон шүүхийн практикт завдах гэдэгт тухайн этгээд санаатай гэмт хэрэг буюу зөрчлийн хуулийн бүрэлдэхүүнийг өөрийн төсөөллөөр шууд гүйцэтгэж эхэлсэн боловч хараахан дуусгаагүй байгааг ойлгоно. Бэлтгэхтэй харьцуулахад завдалтын институт нь ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2 дугаар бүлгийн 2 дахь хэсгээр нэлээд нарийн зохицуулагддаг. Мөн хуулийн 22 дугаар зүйлд завдалтыг *“Тухайн этгээд өөрийн төсөөллөөр хуулийн бүрэлдэхүүнийг шууд хэрэгжүүлж эхлэхийг гэмт хэрэг үйлдэхээр завдах гэнэ”*<sup>20</sup> хэмээн тодорхойлжээ. Үүнээс үзэхэд, уг хэм хэмжээ гэмт үйлдэл хийх талаарх төсөөлөлд үндэслэгдсэн байна. Тухайн үйлдэл хүссэн үр дүнд хүргэж чадах байсан эсэх нь чухал биш. Хуулийн 23 дугаар зүйлд завдалтад оногдуулах ялын хязгаарыг тогтоосон байдаг: гэмт хэрэг үйлдэхээр завдсан тохиолдолд заавал ял хүлээлгэх бөгөөд харин зөрчил гаргахаар завдсан бол хуульд заасан нөхцөлд л ял оногдуулна. Хэрэв гэмт үйлийн субъект эрх зүйн үнэт зүйл – гэмт үйлийн объектод шууд нөлөөлж эхэлсэн бол түүнд бодит аюул учруулсан завдалт гэж үзнэ. Нийтлэг журмын дагуу завдалтад төгс гэмт хэргээс хөнгөн ял оногдуулна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлд завдалтаас сайн дураараа татгалзах боломжийг хуульчилжээ. Энэ тохиолдолд гүйцэтгэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. Тухайлбал, завдалтаас сайн дураараа татгалзах хоёр төрөл байдаг. Үүнд:

- 1) Төгсөөгүй завдалтыг сайн дураараа зогсоосон, гэмт үйлээ цаашид үргэлжлүүлээгүй гүйцэтгэгчийг шийтгэхгүй.
- 2) Төгссөн завдалтын үед гэмт үр дагаврыг зайлуулах идэвхтэй үйлдэл хийсэн гүйцэтгэгчид мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

<sup>20</sup> Эрик Хилгендорф, Д.Чанцалдулам, Германы эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, УБ., 2015, 113 дахь тал.

Мөн хуулийн 24 дүгээр зүйлд гүйцэтгэгчийн оролцоогүйгээр гэмт үйл дууссан бөгөөд “тэрээр уг гэмт үйлийг туйлд нь хүргэхгүйн тулд сайн дураараа шаргуу хүчин чармайлт гаргасан бол ял хүлээлгэхгүй” талаар заажээ.

**Төгс гэмт үйл** – Германы эрүүгийн эрх зүйн өвөрмөц онцлог бол төгс гэмт хэргийг гэмт хэрэг үйлдэж дуусах болон гэмт хэргийг төгсгөх гэсэн хоёр шат болгон хуваадаг явдал юм. Хуулийн бүрэлдэхүүний бүх шинжийг гүйцэтгэсэн бол гэмт хэрэг дууссан гэж үзнэ. Энд гэмт хэрэг бодитойгоор төгссөн эсэх нь ач холбогдолгүй.<sup>21</sup>

**ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн XIX бүлэг “Хулгайлах болон хууль бусаар эзэмших”-д хулгайлах гэмт хэргийн талаар дэлгэрэнгүй, тодорхой байдлаар хуульчилжээ.**

<b>242 дугаар зүйл. Хулгайлах</b>
1. Бусдын хөдлөх эд юмсыг өөртөө болон гуравдагч этгээдэд хууль бусаар шилжүүлэхийн тулд санаатай авсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл торгох ял шийтгэнэ.
2. Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.
<b>243 дугаар зүйл. Онц ноцтой хулгай</b>
1. Хулгайлах гэмт хэргийг онц ноцтойгоор үйлдсэн бол гурван сараас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Онц ноцтой гэдэгт:
1) гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдэхдээ барилга, албан буюу бизнесийн өрөө, эсвэл бусад төрлийн түгжээтэй өрөөг эвдэлж орсон, нэвтэрч орсон, буруу түлхцэр, эсвэл онгойлгох зориулалтын бус багаж хэрэгсэл ашиглан нэвтэрч орсон, эсвэл тухайн өрөөнд нуугдаж үлдсэн,
2) гэмт хэрэгтэн хаалттай сав, эсвэл бусад төрлийн хулгайлахаас онцгойлон хамгаалсан хэрэгсэл дотроос эд зүйлс хулгайлсан,
3) сүм, эсвэл бусад төрлийн шашны зан үйл хийдэг барилга буюу өрөөнөөс мөргөл үйлдэх буюу шашны хүндэтгэл үйлдэх зориулалт бүхий эд зүйлс хулгайлсан,
2. Ялимгүй үнэтэй эд зүйлсийн хувьд энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийн 1-6-д заасан тохиолдлууд хамаарахгүй.
<b>244 дүгээр зүйл. Зэвсэглэсэн; бцлэглэсэн; орон байрны хулгай</b>

<sup>21</sup> С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, I боть, УБ., 2009, 845-862 дахь тал.

1. Хэрэв:

- 1) ...гэмт хэрэг үйлдэхдээ орон байрыг эвдэж орсон, нэвтэрсэн, түлхүүр, эсвэл онгойлгох зориулалтын бус багаж хэрэгсэл ашиглан нэвтэрч, эсвэл тухайн орон байранд нуугдаж үлдсэн бол зургаан сараас арван жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 2) Уг гэмт хэргийн завдалтад ял оногдуулна.
- 3) Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-3-т заасан гэмт хэргийн хүндэвтэр тохиолдлын хувьд гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- 4) Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан орон байрны хулгай нь байнга оршин суудаг хувийн орон сууцтай холбоотой бол нэгээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

246 дугаар зүйл. Бусдын хөдлөх эд юмсыг хууль бусаар эзэмшсэн буюу гуравдагч этгээдэд эзэмшүүлсэн тохиолдолд энэ хуулийн өөр зүйл заалтын дагуу ял шийтгэхээргүй бол гурван жил хүртэл хугацаагаар хорих, эсвэл торгох ял шийтгэнэ.

**248а дугаар зүйл. Ялимгүй цнэтэй эд зүйлс хулгайлах, хууль бусаар эзэмших**

Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага хөндлөнгөөс нийтийн тусгай ашиг сонирхлын цүднээс оролцож буйгаас бусад тохиолдолд энэ хуулийн 242 болон 246 дугаар зүйлд заасан ялимгүй цнэтэй эд зүйлс хулгайлсан, хууль бусаар эзэмшсэн гэмт хэргийг зөвхөн өргөдлийн үндсэн дээр мөрдөн шалгана.

**Товч дүгнэлт:** ХБНГУ-ын эрүүгийн эрх зүйд гэмт хэрэгт шийтгэл оногдуулахдаа хууль тогтоомжид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнд тулгуурлан, урьдчилж заасан бүтцийн тусламжтай шалгаж зүйлчилдэг. Ингэснээр хууль хэрэглэхэд хялбар болох ба тодорхой бүтэц, тогтолцоо бүхий эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг иргэд урьдчилан мэдэх зэрэг ил тод, нээлттэй, шударга байдал бүрддэг. Мөн аливаа гэмт хэрэгт зүйлчлэл хийхдээ хуулийн бүрэлдэхүүний бүх шинжийг хангасан байхыг гэмт хэрэг дууссан гэж үздэг нь завдсан, төгссөн шинжүүдийг ялгах бас нэгэн зааг юм. ХБНГУ-ын Эрүүгийн эрх зүйд ямар ч тохиолдолд завдалтад төгс гэмт хэргээс хөнгөн ял оногдуулдаг аж.<sup>22</sup>

Хулгайлах гэмт хэргийн тухайд хууль бусаар эзэмших гэмт хэрэгтэй хамт нэг бүлэгт зүйлчилсэн байх бөгөөд ХБНГУ-ын ЭХ-

<sup>22</sup> ХБНГУ-ын 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Завдалтын эрүүгийн хариуцлага нь төгссөн гэмт хэргийн хариуцлагаас хөнгөн байж болно.

ийн 242-248 дугаар зүйлүүдэд тодорхой заажээ. Ингэхдээ, гэмт хэргийн зүйлчлэл болон ялын хувьд маш уян хатан зохицуулсан байна. Тодруулбал, ялын маш өргөн сонголттой ба хорих ялын хувьд энэ гэмт хэрэгт гурван сараас арван жил хүртэл, торгох ялын хувьд 5-365 өдрийн ханшаар торгохоор хуульчилжээ. Мөн гэмт хэрэгтний үйлдсэн гэм буруугийн хэлбэр, үйлдэгдсэн нөхцөл байдал, санаа зорилго зэргийг харгалзахаас гадна хувийн орлого, түүний эх үүсвэрийг үндэслэх ба бага орлоготой хүнд их торгууль оногдуулдаггүйгээрээ онцлогтой.

Онц ноцтой хулгайн гэмт хэрэгт ялимгүй буюу бага хэмжээний үнэтэй эд зүйлс хулгайлсан бол хамаардаггүй аж. Орон байранд (байнга оршин суудаг) нэвтэрч үйлдсэн бол зургаан сараас арван жил хүртэлх хорих ял оногдуулах зэрэг ялын уян хатан зохицуулалттай байдаг. Мөн энэ тохиолдолд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан тэнсэх боломжтой.<sup>23</sup>

<sup>23</sup> ХБНГУ-ын ЭХ-ийн

56 дугаар зүйлийн 1. “Нэг жил хүртэлх хугацааны хорих ялаар шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэрээр анхааруулга авч, ялын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхээргүй байвал шүүх түүний ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлж тэнсэж болно. Ингэхдээ яллагдагчийн хувийн зан чанар, түүний өнгөрсөн амьдрал, үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэний дараах байдал, амьдралын нөхцөл байдал, ялыг түдгэлзүүлбэл гарах үр нөлөө зэргийг харгалзан үзэх шаардлагатай.”

56 дугаар зүйлийн 2. “Хоёр хүртэлх жилийн хорих ялаар шийтгүүлсэн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг болон зан чанарыг харгалзан үзэж онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тэнсэн харгалзаж болно. Ийнхүү шийдэхдээ гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан, барагдуулахаар хичээж байгаа байдлыг харгалзан үзнэ.”

## 2.2. ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 8 дахь хэсэг Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, 21 дүгээр бүлэг Өмчийн эсрэг гэмт хэрэг

### **158 дугаар зүйл. Хулгай**

1. Бусдын эд хөрөнгийг нууцаар, хууль бусаар авч ашиглан шамишгдуулсан бол наян мянга хүртэл рубль, эсхүл зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл гурван зуун жаран цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл дөрвөн сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ хэргийг:
  - а) Орон байр, агуулах саванд хууль бусаар нэвтэрч үйлдсэн; бол хоёр зуун мянга хүртэл рубль, эсхүл арван найман сарын цалин хөлс, бусад орлогыг хураах, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр хоёр жил хүртэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх ял шийтгэнэ.
  - б) Хүн амьдрах орон сууц, гэрт хууль бусаар нэвтэрч үйлдсэн; бол нэг зуун мянгаас таван зуун мянга хүртэл рубль, эсхүл нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл хагас жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх, эсхүл хагас жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр наян мянга хүртэл рубль, эсхүл зургаан сар хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгож зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эндээс үзэхэд хулгайн гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн, бусад үйлдэгдсэн нөхцөл байдлаас үл хамааран торгох, эрх хасах, албадан хөдөлмөр хийлгэх, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эрх чөлөө хязгаарлах, баривчлах, хугацаатай хорих зэрэг ялын сонголт өргөн байна. Ингэхдээ энэ гэмт хэрэгт хоёр сараас арван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах боломжтой байдлаар хуульчилжээ.

ОХУ-ын ЭХ-ийн нэг гол онцлог нь төгсөөгүй болон төгссөн гэмт хэргийн тухай зохицуулалтыг тодорхой хуульчилсан байх



ба “Тухайн этгээдийн үйлдсэн хэрэг нь энэ хуульд заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан байвал төгссөн гэмт хэрэг гэж үзнэ”<sup>24</sup> хэмээн заасан байна. Харин ЭХ-д заасан гэмт хэргийн шинжийг хангасан ч хор аюул нь ялимгүй бол гэмт хэрэгт тооцохгүй байхаар тусгажээ.<sup>25</sup>



---

<sup>24</sup> ОХУ-ын ЭХ-ийн 29 дүгээр зүйл. Төгсөөгүй гэмт хэрэг.

29.2. Гэмт хэрэгт бэлтгэх, гэмт хэрэг үйлдэхээр завдах нь төгсөөгүй гэмт хэрэг болно.

30 дугаар зүйлийн 3. “Гэмт хэрэг үйлдэхээр завдах гэдэг нь тухайн этгээдийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэргийг төгсгөж чадаагүй гэмт хэрэг шууд үйлдэхэд чиглэсэн этгээдийн санаатай үйлдэл (идэвхгүй үйлдэл) юм.”

<sup>25</sup> ОХУ-ын ЭХ-ийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

## 2.3. БНХАУ-ЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### **БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйл (Эд хөрөнгөд халдсан ял)**

*“Албаны ба хувийн зоос мөнгө, эд бодисыг хулгайлсан тоо хэмжээ нь нэлээд их буюу олон удаа хулгайлсан байвал гурваас доош жилийн хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх<sup>26</sup> буюу захиран хамаарахаар<sup>27</sup> шийтгэж, зоосоор торгохоор<sup>28</sup> нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ.*

*Тоо хэмжээ нь тун их буюу бусад талын хүнд ноцтой үйл байдалтай байвал гурваас арван жилийн хугацаатай хорихоор<sup>29</sup> шийтгэж, зоосоор торгохоор нийлүүлэн шийтгэнэ.*

*Тоо хэмжээ нь онцгой их буюу бусад талаар онцгой хүнд ноцтой үйл байдалтай байвал арваас дээш жилийн хугацаатай хорих буюу хугацаагүй хорихоор шийтгэж, зоосоор торгох буюу эд хөрөнгийг нь хурааж авахаар<sup>30</sup> нийлүүлэн шийтгэнэ.*

<sup>26</sup> БНХАУ-ын ЭХ-ийн 42 дугаар зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэх хугацаа нэгээс зургаан сар байна. 43 дугаар зүйл. Хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэгдсэн ялт этгээдийг дотоодыг хамгаалах байгууллага ойрхон газарт ял эдлүүлнэ. Ял эдлүүлэх хугацаанд хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэгдсэн ялт этгээд сард нэгээс хоёр удаа гэртээ харьж болно.

<sup>27</sup> БНХАУ-ын ЭХ-ийн 38 дугаар зүйл. Захиран хамаарах хугацааг гурван сараас хоёр жил хүртэлх хугацаагаар шийтгэгдсэн ялт этгээдийн ялыг дотоодыг хамгаалах байгууллагаас гүйцэтгэнэ. 39 дүгээр зүйл. Захиран хамаарагдахаар шийтгэгдсэн ялт этгээд ял гүйцэтгэлийн хугацаандаа доорх журмыг сахих хэрэгтэй:

1. Хууль цааз, засаг захиргааны хууль тогтоолыг журамлан сахиж, хяналтыг дагах;
2. Гүйцэтгэх байгууллагын зөвшөөрөлгүйгээр саналаа хэлэх, хэвлэн нийтлүүлэх, хурал цуглаан хийх, эвлэн хорших, жагсаал явуулах, сүр үзүүлэх чөлөөтэй эрхийг хэрэглэж болохгүй;
3. Гүйцэтгэх байгууллагын тогтоолоор өөрийн ажлын байдлаа мэдүүлэх;
4. Зочинтой уулзах тухай гүйцэтгэх байгууллагын тогтоолыг журамлан сахиж;
5. Сууж байгаа хот, саян-аас гадагш гарах буюу нүүж явахдаа гүйцэтгэх байгууллагад мэдүүлэх.

<sup>28</sup> БНХАУ-ын ЭХ-ийн 52 дугаар зүйл. Зоосоор яллахаар шийтгэхдээ ял хийсэн үйл байдлыг үндэслэж яллах зоосны тоог тогтоох хэрэгтэй.

53 дугаар зүйл. Ялласан зоосыг шүүн таслалтад тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаанд хувааж тушаана. Хугацаа дүүртэл тушаахгүй байвал албадан тушаалгана. Ялласан зоосыг бүгдийг тушааж дийлэхгүй байвал ардын шүүх хорооноос аль ч үед эд хөрөнгө бий болсныг олж мэдвэл тухай бүр нь нэхэмжлэн тушаалгана. Давагдашгүй гай гамшиг учраад тушаахад үнэхээр хүчиртэй болсон байвал байдлыг харгалзаж багасгах буюу хэлтрүүлж болно.

<sup>29</sup> БНХАУ-ын ЭХ-ийн 45 дугаар зүйл. Тус хуулийн 50 дугаар зүйл, 69 дүгээр зүйлд тогтоосныг зөрчвөл зургаан сараас 15 жил хорино.

46 дугаар зүйл. Хугацаатай хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн ялыг гянданд буюу бусад гүйцэтгэх байгууллагад гүйцэтгэнэ. Хөдөлмөрлөх чадалтай нь цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжил хүртэж өөрчлөгдөх хэрэгтэй.

<sup>30</sup> БНХАУ-ын ЭХ-ийн 59 дүгээр зүйл. Эд хөрөнгийг нь хураан авах нь ялт этгээдийн хувийн өмчлөлийн эд хөрөнгийн нэг хэсэг буюу бүгдийг хураан авах явдал болно. Бүх эд хөрөнгийг хураан авахдаа ялт этгээд жич түүний гэр бүлийнхэнд хэрэгцээ бүхий амьдралын зардлыг үлдээж өгөх хэрэгтэй. Эд хөрөнгийг нь хураан авахаар шийтгэхдээ ялт этгээдийн гэр бүлийнхний өмчлөлд тооцогдох буюу эдлэх ёстой эд хөрөнгийг хураан авч болохгүй.

*Дараах нөхцөлцүдийн аль нэг нь байвал хугацаагүй хорих буюу хороох шийтгэлээр<sup>31</sup> шийтгэж, эд хөрөнгийг нь хурааж авахаар нийлцүлэн шийтгэнэ:*

1. Тоо хэмжээ нь онцгой их мөнгөн гүйлгээний байгууламжийг хулгайлах;
2. Ховор нандин түүхийн дурсгалт зүйлсийг хулгайлаад үйл байдал нь хүнд ноцтой байх;

гэж нэлээд их, тун их, онцгой их хохирол учруулснаас бусад тохиолдолд гэмт хэрэг болохгүй талаар зохицуулжээ.

Мөн гэмт хэрэг эхэлсэн боловч ялт этгээдийн санаа зоригоос гадна шалтгаанаас болж биелүүлж эс чадсаныг завдалт (татмаг ял хийх) гэнэ. Татмаг ажиллагаат хэрэгтэн (завдсан этгээд)-ийг гүйцэд ажиллагаат хэрэгтний тухай зүйл зурвастай харьцуулж үзэн хөнгөнөөр шийтгэх буюу хөнгөлж шийтгэж болно<sup>32</sup> хэмээн гэмт хэргийн завдалтад төгссөн гэмт хэрэгт оногдуулах ялаас хөнгөн ял оногдуулахаар зохицуулжээ.<sup>33</sup>

<sup>31</sup> БНХАУ-ын ЭХ-ийн 48 дугаар зүйл. Алах шийтгэлийг гагцхүү туйлын хүнд ял хийсэн ялт этгээдэд хэрэглэнэ. Алахаар шийтгэх хэрэгтэй ялт этгээдийг заавал дор нь гүйцэтгэх хэрэгтэй биш байвал алахаар шийтгээд хоёр жил хойшлуулан гүйцэтгэхээр шийдэж болно.

<sup>32</sup> БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 23 дугаар зүйл.

<sup>33</sup> Ж.Эрдэнэбулган, Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, УБ., 2021, 312 дахь тал.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн зүйлчлэл, бүрэлдэхүүний уламжлалт шалгуур, ойлголтыг шинээр авч үзэн, орчин үеийн онол, арга зүйд тулгуурлан, ялын бодлогод хүмүүнлэг хандлагыг бий болгох зорилгоор 2015 оны Эрүүгийн хуулийг баталсан юм. Ингэхдээ хуулийн агуулга, заалт нөхцөлүүдийг олон улсын эрүүгийн эрх зүйн буюу НҮБ-ын Хүний эрхийн конвенц, стандарт, зарчмуудтай уялдуулах байдлаар нийцүүлэхийг эрмэлзэж байна. Энэ хүрээнд гэмт хэргийн бүлэглэлтийг зохистой төрөлжүүлж, Эрүүгийн хуульд оновчтой зүйлчлэн томъёолох хэрэгцээ, шаардлага байсаар байна.

### **Эрүүгийн эрх зүйн онолын хүрээнд**

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх хэсэгт “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” гэж заасан нь “гэмт хэргийн үндсэн шинжийг хангахгүйгээр хүндрүүлэх боломжгүй” гэх бүрэлдэхүүний салшгүй байх онолын ойлголтыг үгүйсгэж буй юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн үндсэн нөхцөлд “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол...” гэж заасан нь энэ гэмт хэргийн үндсэн шинж бөгөөд гэмт хэрэгтэн бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар, нууцаар өөрийн өмчлөлд авах буюу өөрийн өмчийн адил эзэмших, ашиглах, захиран зарцуулах боломж бий болгосон, захиран зарцуулсныг ойлгох

учиртай. Харин гэмт хэрэгтэн бусдын орон байр, агуулахад гэм буруугийн санаатай хэлбэрээр, шунахайн сэдэл, зорилготойгоор “нэвтэрсэн” бол үндсэн шинжийг хангах буюу гэмт хэргийг шууд төгссөнд тооцох боломжгүй. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан хүнийг алах гэмт хэргийн үндсэн шинж болох “Хүнийг алсан бол...” гэх шинжийг хангахгүйгээр хүндрүүлэх нөхцөлд заасан “Хүнийг:” “онц харгис хэрцгийгээр;” “...алсан бол” гэж хүндрүүлэх онолын болон хууль зүйн үндэслэл байж болохгүй.

Мөн Эрүүгийн эрх зүйд аливаа гэмт хэргийн бүрэлдэхүүний хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинж нь бие даасан байдалтай гэж үздэг ч тухайн гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжийг зайлшгүй хангасан байхыг ихэнх гэмт хэрэгт (Тусгай ангийн зүйл, хэсэгт) шаарддаг.

Дээр судлагдсан гадаадын зарим оронд Эрүүгийн хуулийн зохицуулалтуудаас үзэхэд хулгайлах гэмт хэргийг орон байранд нэвтэрсэн хулгай, агуулах саванд нэвтэрсэн хулгай, ердийн хулгай гэж тусдаа зүйл бүрээр ялган хуульчилсан нь харагдах боловч гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд үндсэн бүрэлдэхүүний нэг хэсэг байхаар хуульчилж тогтоосон нь гэмт хэргийн бүрэлдэхүүний онолын ойлголтыг манай улстай нэгэн адил хэрэглэж байгааг харуулж буй юм.

Хэдийгээр энэ гэмт хэргийн хувьд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах буюу орон байр, тусгайлан хамгаалсан байранд нэвтрэх үйлдэл давхар үйлдэгдэх боловч уг гэмт хэргийн үндсэн объект нь бусдын эд хөрөнгө байгаа тохиолдолд ямагт үндсэн шинжийг эхэнд авч үзэн түүний бүрдэл, төгссөн байдлыг харгалзан үзэх нь Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн үзэл баримтлалыг илэрхийлнэ.

Иймд “хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч” үйлдсэн хулгайлах гэмт хэргийн зүйлчлэл нь ямагт бусдын өмчлөх эрх буюу бусдын эд хөрөнгийг өөрийн өмчлөлдөө шилжүүлэн авсан үйлдэлд үнэлэлт өгөх замаар зүйлчлэх ёстой гэж үзэж байна.

### **Эрх зүйн зохицуулалтын хүрээнд**

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг” гэж хуульчилсан нь гэмт хэргийг хүндрүүлэх, онц хүндрүүлэхдээ гэмт хэргийн үндсэн шинжийг хангасан байхыг шаардаж буй хэлбэр юм. Энэ нь гэмт хэргийн үндсэн шинжийг зайлшгүй хангаснаар гэмт хэргийг хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинжээр зүйлчилнэ гэсэн үг юм. Гэмт хэрэг бүр дахин давтагддаггүй боловч “нэвтэрсэн” хулгайн гэмт хэргийн хувьд ихэнх нь гэмт хэрэг үйлдсэн хүний хүсэл зоригоос хамаарахгүйгээр өөр бусад гэрч, эсхүл хохирогч таслан зогсоож, үйлдэл дээр нь барьж, шаардсанаар зогссон байдаг онцлогтой. Үүнээс үзвэл Эрүүгийн хуульд заасан “завдалт”-ын хувьд ч эцэслэн шийдвэрлэх асуудлууд буйг илтгэнэ.

### **Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний хүрээнд**

Шүүхийн практикт яг ийм онолын болон эрх зүйн хэм хэмжээний эсрэг байр суурь, үндэслэлүүдээр хэрэг маргаан шийдвэрлэгдэж байгаа нь дээрх судалгаанаас тодорхой харагдах ба хуулийн дээрх зохицуулалтыг Эрүүгийн эрх зүйн гэмт хэргийн хууль ёсны болон зайлшгүй байх гэсэн зарчмуудад үндэслэн боловсронгуй болгох шаардлагатай байна. Угтаа хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсгүүдэд тодорхой гэмт хэргийг үйлдэгдэж төгссөн байдлаар хуульчилж, гэмт хэрэгт бэлтгэх, завдах үйлдлийг тусгадаггүй.

Мөн эрүүгийн эрх зүйн онолын хувьд тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх шинжээр зүйлчлэхдээ тухайн гэмт хэргийн үндсэн шинжийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, дээрх шүүхийн шийдвэрүүдийн тохиолдолд гэмт хэргийн үндсэн шинжийг бүрэн хангаагүй байхад гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэж үзэх нь үндэслэлтэй байж болохоор байна. Үүнээс гадна гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох, тайлбарлахад тус Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэг, заалтын зэрэгцээ тусгай ангийн тогтолцоо, тодорхой бүлэг, зүйлийн гарчиг ач холбогдолтой байдаг. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасанчлан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг мөн бөгөөд энэ тохиолдолд гэмт хэргийг тайлбарлаж, зүйлчлэхдээ өмч, өмчлөх эрхийн ойлголтыг заавал авч үзэх шаардлагатай ба өмчлөх эрх гэдэг нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах талаарх өмчлөгчийн бүрэн эрх (энэ гэмт хэргийн объект) гэдэгт зайлшгүй хууль зүйн дүгнэлт хийх шаардлагатай.

## ЗӨВЛӨМЖ

1. Дээрхээс үзэхэд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад заасан “...байр, агуулахад нэвтэрч” гэх шинжээр хэргийг зүйлчлэхдээ тухайн гэмт хэргийн “...авсан бол” гэх үндсэн шинжийг зайлшгүй анхаарах шаардлагатай ба энэ нь гэмт хэргийг завдсан, төгссөн үйлдэл, тэдгээрийн зүйлчлэлд чухал ач холбогдолтой юм. Тодруулбал, хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч үйлдсэн хулгайлах гэмт хэргийн тухайд:
  - гэмт этгээд бусдын эд хөрөнгийг өөрийн эзэмшилдээ авч захиран зарцуулсан, эсхүл захиран зарцуулах бодит боломж бий болсон эсэх нөхцөл байдлыг харгалзан тухайн гэмт хэргийг төгссөн гэж үзэх;
  - харин дээрх нөхцөл байдал бий болоогүй, эсхүл тогтоогдохгүй байгаа тохиолдолд тухайн гэмт хэргийг үйлдэхээр завдсан; гэх байдлаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь зүйтэй байна.
2. Мөн дээрх хууль хэрэглээний асуудлыг Эрүүгийн хуулийн тухайн гэмт хэргийн зүйл, хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахгүйгээр зөвлөмж, сургалт зэргээр шийдвэрлэх бүрэн боломжтой бөгөөд энэ нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлал болоод орчин үеийн чиг хандлагад нийцнэ.



## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

### **Эрх зүйн баримт бичиг**

1. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл №7, 2016.
2. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай, МУДШ-ийн 2006 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоол.
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ын ЕА-н 217/А/ III/ тогтоол, 1946.
4. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, НҮБ-ын ЕА-н 2200А(XXI) 1966-1976, 1968-1974.

### **Гадаад улсын хууль**

1. ОХУ-ын Эрүүгийн хууль.
2. ХБНГУ-ын Эрүүгийн хууль.
3. БНХАУ-ын Эрүүгийн хууль.

### **Ном, сурах бичиг, бусад эх сурвалж**

1. Г.Гантөмөр, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги (сурах бичиг), 2020.
2. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй: Тусгай анги (сурах бичиг), 2020.

3. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол, I боть, 2009.
4. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (Ялын тухай сургаал), II боть, 2014.
5. Э.Хилгэнфорд, Д.Чанцалдулам, Монголын эрүүгийн эрх зүйн шинэтгэл Монгол-Герман харьцуулсан ЭЭЗ-н эрдэм шинжилгээний илтгэлүүд, 2018.
6. Ж.Эрдэнэбулган, Монгол, Орос, Хятад, Герман Улсын эрүүгийн хууль, 2021.

### **Цахим эх сурвалж**

1. Шүүхийн шийдвэрийн цахим сан.
2. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
3. Ханнс Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академи “Эрүүгийн эрх зүй цуврал хичээл 2” 2019.
4. Model Codes for Post-conflict. Criminal Justice Model Criminal Code, Vivienne O'Connor and Colette Raush editors, Peasbuilding and the Rule of law. WPL, 2007.
5. Ханнс Зайделийн сан, МУДШ, Эрүүгийн эрх зүй (Сургалтын гарын авлага), 2011.

### **Холбоос**

[www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

[www.legaldata.mn](http://www.legaldata.mn)

# 2

## ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИХ ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### ПҮРЭВЖАЛЫН НАМУУН

Нийгэм, эрх зүйн бодлогын судалгааны “Судлаач” хүрээлэн ТББ-ын захирал, судлаач.

Хууль, эрх зүйн салбарын судалгаа, хуулийн мэдлэг мэдээллийг нийтэд түгээх, нөлөөлөх чиглэлээр дагнан ажиллаж байна.

Эрдэм шинжилгээний өгүүлэл 5, дангаар болон хамтарсан судалгааны ажил 10 орчим, хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл олгох чиглэлээр сэтгүүл зүйн бичвэр нийтлэл 10 гаруйг бичиж олны хүртээл болгожээ.

Судлаачид:

П.Намуун

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	53
ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	54
УДИРТГАЛ.....	55
<b>НЭГ. ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИХ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.....</b>	<b>60</b>
1.1. Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн шинж, өнөөгийн байдал.....	62
<b>ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....</b>	<b>68</b>
2.1. Эрх бүхий албан тушаалтан бусдыг хууль бусаар мөрдөж мөшгисөн тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	68
2.2. Бусдын захиалгаар иргэнийг мөрдөж мөшгисөн тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	73
2.3. Бусдын гэрийн хаяг, утсыг олж авахаар хууль бусаар мөрдөж мөшгисөн тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.....	76
2.4. Бусдын тээврийн хэрэгсэлд байршил тодорхойлох, чагнах төхөөрөмж суурилуулан мөшгисөн тухай шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ .....	87
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>92</b>
<b>САНАЛ.....</b>	<b>94</b>
<b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ .....</b>	<b>95</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АТГ	Авлигатай тэмцэх газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХЕА	Эрүүгийн хуулийн ерөнхий анги
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭЦА	Эрүүгийн цагдаагийн алба

## ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

График 1. Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй хэлбэрүүд.....	65
Хүснэгт 1. Шүүхийн шийдвэр .....	58
Шигтгээ 1. Ярилцлагын судалгааны тэмдэглэл.....	64

## УДИРТГАЛ

Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг нь 2015 оны Эрүүгийн хуульд шинээр тусгагдсан шинэ төрлийн гэмт хэрэг бөгөөд хүний эрх, эрх чөлөө, хувь хүний халдашгүй байдлыг сахин хамгаалах нэг төрлийн эрх зүйн баталгаа юм. Өмнө нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг “Иргэдийн улс төрийн болон бусад эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг”-т тусгасан Жагсаал цуглаан хийх эрх чөлөөг зөрчих, Иргэнийг үзэл бодлоор нь мөрдөн мөшгих, Шүтэж буй шашнаар нь ялгаварлан гадуурхах, мөрдөн мөшгих гэмт хэргүүдэд хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн шинж агуулагдаж байсныг дурдах нь зүйтэй.

Эрүүгийн хууль (2015 оны шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлснээс хойш зургаан жилийн хугацаанд энэ төрлийн нийт долоон хэргийг шүүхээр шийдвэрлэсэн нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт багадаа биш иргэдийн эрх зүйн мэдлэг мэдээлэл дутмагийн улмаас тус гэмт хэрэгт хохирсноо мэдэхгүй, хууль хяналтын байгууллагад хандахгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Ардчилсан улс орон, эрх зүйт төрийн хувьд иргэд нь хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө хуулийн дагуу хамгаалж, хамгаалуулж чаддаг байх нь эрх зүйн хөгжлийн нэгэн үзүүлэлт болдог.

Түүнчлэн Доктор (Ph.D) Б.Энхболд 2019 онд бичсэн “Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг гэмт хэрэгт хохирох явдлын

судалгаагаар тооцсон байдал”<sup>1</sup> сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлдээ “Тодорхой төрлийн гэмт хэргийн дотроос авлигын гэмт хэрэг 7.5 дахин, хүчиндэх, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг 5.8 дахин, мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 6.3 дахин, хууль бусаар мөрдөн мөшгих гэмт хэрэг 4.5 дахин, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4.2 дахин их байгаа нь анхаарал татаж байна” хэмээн дүгнэжээ. Энэ нь нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй нь аюулгүй мэтээр нийгмийн дунд оршин тогтнож, гэмт этгээдүүд хуулийн хариуцлагаас мултарч, хохирогчид хууль ёсны эрх зүйн хамгаалалтыг хүлээн авч чадахгүй байгааг шууд илтгэж буй юм. Иймээс энэхүү судалгаагаар Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийх дүн шинжилгээний хүрээнд практикт энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж буй байдал, хууль зүйн нэр томьёо, ухагдахууныг хэрхэн тайлбарлаж, үнэлж буйг тодорхойлов.

Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг шалган шийдвэрлэж буй байдал, практикт тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг судалж, хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн ил тод байдал, чанарыг сайжруулахад нөлөөлөх зорилгоор дараах зорилтын хүрээнд судалгааны ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн бүрэлдэхүүний онол, эрх зүйн зохицуулалтыг судлах;
- Энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж буй байдлыг судлан дүгнэх;
- Хэрэг шийдвэрлэхэд практикт тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох;

<sup>1</sup> Б.Энхболд, “Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаагаар тооцсон байдал”, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл №1(67), УБ., 2016.



- Хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэж буй хуулийн зохицуулалт, хууль хэрэглээнд дүн шинжилгээ хийх;
- Энэ төрлийн гэмт хэргийн шүүхийн шийдвэр агуулга, хэлбэрийн хувьд хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг судлах;
- Энэ төрлийн гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн ил тод, нээлттэй байдлын ач холбогдлыг тодорхойлох;
- Шүүхийн шийдвэрийг сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулах.

Судалгааг Нээлттэй Нийгэм Форумын “Шүүхийн шийдвэрийн судалгааны аргачлал”-ыг удиртгал болгон түүнд дурдсан тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглан боловсруулав. Чанарын судалгаанд баримт бичгийн судалгааны аргыг түлхүү хэрэглэсэн бөгөөд судалгааны үр дүнг урьдчилан таамаглаж, хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн хохирогчид хууль хяналтын байгууллагад ханддаг эсэхийг тандан судлахаар контент анализын болон ярилцлагын аргыг мөн ашигласан болно.

Шүүхийн шийдвэрийн [www.suukh.mn](http://www.suukh.mn) цахим санд энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой анхан шатны болон давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэсэн нийт найман шийдвэр байх бөгөөд Улсын Дээд шүүхээр шийдвэрлэсэн хэрэг одоогоор байхгүй байна. Дээр дурдсан найман шийдвэрт:

- анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасныг анхан шатны шүүхэд буцаасан шийдвэр гурав,
- анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн нэг хэрэг буюу нийт шийдвэр хоёр,
- хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шийдвэр хоёр байх бөгөөд нэг нь давж заалдах шатны шүүхэд хандаж түүнийг шийдвэрлэсэн шийдвэрүүд тус тус багтаж байна.

Хүснэгт 1. Шүүхийн шийдвэр

Шийдвэрийн дугаар	Хэргийн агуулга	Шийдвэрлэсэн байдал	Давуу тал
<b>Анхан шатны шүүхийн шийдвэрүүд</b>			
2020/ ШЦТ/277	Г.О нь өөрт хамааралгүй хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.	ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай; 5400 нэгжтэй тэмцэх хэмжээний төгрөгөөр торгох ялаар шийтгэж шийдвэрлэсэн.	-
2021/ ШЦТ/284	А.Т нь бусдын захиалгаар хүнийг мөрдөж мөшгисөн.	ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хорих ялыг оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэх, ЭХЕА-ийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад заасан “зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах” үүрэг, хязгаарлалтыг хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд тогтоож шийдвэрлэсэн.	Үүрэг, хязгаарлалт тогтоосон боловч бусадтай бүлэглэн үйлдсэн байхад захиалсан этгээд мөн хариуцлага хүлээх эсэхэд хууль зүйн дүгнэлт хийгээгүй.
2021/ ШЦТ/566	Б.Б нь өмнө ажиллаж байсан сургуулийн тэнхимийн эрхлэгч Н.Б-гийн гэрийн хаяг, гар утасны дугаарыг олж авахаар шүүгдэгч П.С-д тодорхой хэмжээний төлбөр төлсөн.	Б.Б, П.С нарт холбогдох хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож;	Бусдыг мөрдөж мөшгихөөр мөнгө төлж, хүнээр уг хэргийг гүйцэлдүүлсэн боловч бүлэглэн үйлдсэн гэж үзээд хариуцлага ногдуулсан.
2021/ ШЦТ/392		П.С-д ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан долоон сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялыг өршөөн хэрэгсэхгүй болгож, Б.Б-д оногдуулсан есөн сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.	

2021/ ШЦТ/319	М.Д нь З.Б-н эзэмшлийн “Тоёота Приус” маркийн 93-14 УБВ улсын дугаартай автомашинд хөдөлгөөнт байршил тодорхойлогч, чагнах төхөөрөмж суурилуулсан.	Арван сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж шийдвэрлэсэн.	Нийгмийн аюулын шинжийг харгалзан үзэж хариуцлага оногдуулсан.
<b>Давж заалдах шатны шүүхийн магадлал</b>			
2021/ ДШМ/604	2021/ШЦТ/284 дугаартай анхан шатны шүүхийн шийдвэр	Хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой бөгөөд гэмт хэрэг үйлдсэн гэм буруугийн хувьд маргаангүй шийдвэр гарсан.	
2021/ ДШМ/937	2021/ШЦТ/566 дугаартай анхан шатны шүүхийн шийдвэр	Шүүгдэгч нарыг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжгүй бөгөөд Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг тогтоосон зохицуулалт нь хэдийгээр материаллаг хуульд тусгагдсан боловч зохицуулж байгаа харилцааны мөн чанар, агуулгын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны буюу процессын шинжийг илэрхийлдэг тул хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолохоор тогтоосон хуулийг баримтлах нь зүйтэй хэмээн үзэж өмнөх шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.	
2022/ ДШМ/715	2022/ШЦТ/319 дугаартай анхан шатны шүүхийн шийдвэр	Шүүгдэгч М.Д-н гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 319 дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн.	

## **НЭГ. ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИХ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ**

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд “хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”, 12 дугаар зүйлд “хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд “хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно” гэж заасан бол Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-д “... халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тус тус заажээ.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргүүдийг агуулсан ба тус хуулийн 13.12 дугаар зүйлд “Хууль бусаар мөрдөж мөшгих” гэмт хэргийг хуульчилсан нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх нэгэн алхам болсон билээ.

Олон улсад энэ төрлийн гэмт хэргийг эрүүгийн хууль тогтоомждоо харилцан адилгүй хуульчилдаг. Тухайлбал:

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 137 дугаар зүйлд<sup>1</sup> “Хүний хувийн амьдралын халдашгүй байдлыг зөрчих”<sup>2</sup> гэмт хэргийг тусгасан бөгөөд “Хүний хувийн амьдрал, гэр бүлийн нууцыг агуулсан мэдээллийг түүний зөвшөөрөлгүйгээр **хууль бусаар цуглуулах**, тараах, эсхүл уг мэдээллийг олон нийтэд бүтээл болгон хэвлэн тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараах” хэмээн уг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлжээ.

Австрали улсын Квийнсланд (Queensland) мужийн Эрүүгийн хуульд анх 1899 онд **Unlawful stalking**<sup>3</sup> буюу хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг хуульчилсан байдаг. Энд хүнийг дагах, хэт ойроос ажиглах; утас, шуудан, факс, цахим шуудангаар, эсвэл бусад технологи ашиглан хүнтэй ямар нэгэн байдлаар холбогдох; тухайн хүний амьдардаг, ажилладаг, очдог газрын ойролцоо эргэлдэх, ажиглах, ойртох; бусдыг буруутгасан, доромжилсон материалыг хэн нэгнээс авах, дамжуулах, анхааралд өртөхүйц газар үлдээх; шууд болон шууд бусаар доромжилсон материал бүрдүүлж тараах болон бусад үйлдлийг хүнийг хууль бусаар мөрдөж мөшгисөн гэж тооцохоор хуульчилжээ.

<sup>1</sup> "Уголовный кодекс Российской Федерации" от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 14.07.2022, с изм. от 18.07.2022) (с изм. и доп., вступ. в силу с 25.07.2022)

<sup>2</sup> ОХУ-ын Эрүүгийн хуулийн албан бус орчуулга. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_10699/4234a27af714cc608ea71b7bae9400f3613c8f60/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/4234a27af714cc608ea71b7bae9400f3613c8f60/)

<sup>3</sup> Албан бус орчуулга. [http://classic.austlii.edu.au/au/legis/qld/consol\\_act/cc189994/s359b.html#unlawful\\_stalking](http://classic.austlii.edu.au/au/legis/qld/consol_act/cc189994/s359b.html#unlawful_stalking)

Харин Дэлхийн эрүүгийн загвар хуулийн<sup>4</sup> 105 дугаар зүйлд Гэр бүлийн хүчирхийллийн талаар тусгасан бөгөөд гэр бүлийн хамааралтай хүнийг **мөрдөж мөшгих** нь хүний сэтгэл зүйн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн шинжтэй гэмт үйлдэл мөн гэж үзсэн байдаг.

### 1.1. ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИХ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлд Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг хуульчилсан. Бүрэлдэхүүний хувьд:

1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн бол;
2. Эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгисөн бол хэмээн тус тус заажээ.

**Мөрдөж мөшгих** хэмээх ойлголтыг үгийн уг гарвалиар судлан үзвэл “**мөрдөх**”<sup>5</sup> хэмээх үг нь зам мөрөөр нь хөөн явах; “**мөрдөх мөшгөх**”<sup>6</sup> хэмээх хоршоо үг нь мөрийг нь даган явах гэсэн утгыг илэрхийлдэг бол “**мөшгөх**” гэдэг нь дангаараа хүн, амьтны мөрийг алдалгүй даган нэхэх гэсэн утгатай юм.

Харин судалгааны түүвэр болох шүүхийн шийдвэрт тусгасан “гэмт хэрэгт холбогдсон” талаарх үндэслэлийг шүүж харвал:

- Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2020 оны 08 дугаар сард хялбаршуулсан журмаар

<sup>4</sup> [https://books.google.mn/books?id=FL3nJkyxDBkC&printsec=frontcover&source=gbs\\_ge\\_summary\\_r&cad=0&fbclid=IwAR3dtES3MSib6YpRu8ia2XgKNtlijNwEBTsln2RNOQGn5Ru5Tsx5bY\\_FMY8#v=onepage&q=unlawful%20stalking&f=false](https://books.google.mn/books?id=FL3nJkyxDBkC&printsec=frontcover&source=gbs_ge_summary_r&cad=0&fbclid=IwAR3dtES3MSib6YpRu8ia2XgKNtlijNwEBTsln2RNOQGn5Ru5Tsx5bY_FMY8#v=onepage&q=unlawful%20stalking&f=false)

<sup>5</sup> Монгол толь. <https://mongoltoli.mn/dictionary/detail/58315>

<sup>6</sup> Монгол хэлний зөв бичих дүрмийн тайлбар толиудад “мөшгөх” гэж бичсэн байх боловч уг судалгааны ажилд энэ үгийг Эрүүгийн хуульд бичсэн хэлбэрээр буюу “мөшгих” гэдгээр нь хэрэглэв.

шийдвэрлэсэн 2020/ШЦТ/277<sup>7</sup> дугаартай шийдвэрт “... өөрт нь холбогдох хэргийг шалгаж байсан мөрдөгч Ц.М-ын эзэмшдэг Мобикомын \*\*\*\*\* дугаарын орсон гарсан ярианы мэдээллийг гаргуулан авахаар “Мобиком” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарт албан бичиг хүргүүлсэн ...” гэх эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нөхцөл байдал;

- Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 2021/ШЦТ/284 дугаартай шийдвэрт “... фитнес, гэр хороолол, автобусны буудал зэрэг газраар дагаж, бусадтай уулзаж байх цед нь зургийг нь дарж ...”;
- Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдөр шийдвэрлэсэн 2021/ШЦТ/566 дугаартай шийдвэрт “... гэрийн хаяг, утасны дугаарыг олж авахаар ...”;
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр<sup>8</sup> 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдөр шийдвэрлэсэн 2021/ДШМ/292 дугаартай шийдвэрт “... ярьсан яриаг нууцаар аудио бичлэг хийсэн ...”;
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр шийдвэрлэсэн 2022/ДШМ/715<sup>9</sup> дугаартай шийдвэрт “... автомашинд хөдөлгөөнт байршил тодорхойлогч, чагнах төхөөрөмж суурилуулж, уг төхөөрөмжөө ашиглан 2021 оны 03 дугаар сараас 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд яриаг нь чагнах, худалдааны төвөөс

<sup>7</sup> Цаашид шийдвэрүүдийг зөвхөн шийдвэрийн дугаараар нэрлэнэ.

<sup>8</sup> Анхан шатны шүүхийн шийдвэр нууцлалтай.

<sup>9</sup> Анхан шатны шүүхийн шийдвэрт зөвхөн тогтоох хэсгийг нийтэлсэн.

*гэртээ очтол нь дагах ...”* гэх мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн нөхцөл байдлуудыг тус тус эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг хэмээн үзэж мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүхээр хэлэлцэн шийдвэрлэжээ.

Дээрхээс дүгнэхэд хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг нь тодорхой зорилго агуулан хувь хүний халдашгүй байдлын эсрэг үйлдэж буй санаатай гэмт хэрэг юм.

Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг нь цагдаагийн байгууллагад 2018 онд нэг, 2019 онд дөрөв, 2021 онд хоёр, 2022 оны эхний 08 дугаар сарын байдлаар нэг тус тус бүртгэгдэж,<sup>10</sup> шүүхээр 2020 онд нэг, 2021 онд гурав, 2022 онд нэг тус тус шийдвэрлэгдсэн байна. Энэ нь ийм төрлийн гэмт хэргийн гаралт харьцангуй бага болохыг шууд илтгэх боловч нуугдмал гэмт хэргийн багагүй хувийг эзэлж байгаа тухай өмнөх хэсэгт дурдсан билээ. Түүнчлэн энэ тоон мэдээлэл нь бүртгэгдсэн гомдол, мэдээллээс өөр тоон утга бөгөөд цагдаагийн байгууллагад жилд энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой хэдэн гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс хэдэн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэдгийг мэдэх боломжгүй.

### **Шигтгээ 1. Ярилцлагын судалгааны тэмдэглэл**

Хохирогч Д: Гэр бүлийн хамааралтай хүн буюу нөхөр (салахаар шийдвэр гарган тусдаа амьдраад зургаан сар болж байсан) миний цүнхэнд байрлал тогтоох, яриа бичих боломжтой төхөөрөмж хийсэн байсныг олж мэдээд цагдаагийн байгууллагад өргөдөл гаргасан. Уг хэргийг хариуцсан мөрдөгч “эрүүгийн хэрэг үүсгэхээр санал хүргүүлсэн ч гэр бүлийн хамааралтай хүмүүс учраас шүүх хайхардаггүй гээд прокуророос мөн буцаадаг” гэж хэлээд миний гаргасан

<sup>10</sup> Цагдаагийн ерөнхий газрын албан ёсны сайтаас түүвэрлэн авав. <https://police.gov.mn/>



гомдлыг эрүүгийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж байсан.



Ярилцлагын судалгаанд хамрагдахыг зөвшөөрсөн 12 иргэнээс хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн хохирогч болж байсан эсэхийг тодруулахад 66 хувь буюу найм нь энэ гэмт хэрэгт ямар нэг байдлаар өртөж байсан гэж хариулсан байдаг.

График 1. Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй хэлбэрүүд



Харин тухайн иргэдээс хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн талаарх ойлголтыг тодруулахад:

- Утас чагнах, нийгмийн сүлжээний хэрэгсэлд хууль бусаар нэвтрэх, сэм тандах гэх мэт;
- Хэний ч зөвшөөрөлгүй дагах, мөрдөх, бичлэг хийх гэх мэт;
- Ойлголтгүй; (2 хариулт)
- Хуулийн дагуу хууль бусаар аливаа байдлаар мөрдөж шалгах;
- Тийм байдалд орж байсан ба хаана явж байгааг мэдэх, утсаар зурвас ирэх гэхчлэн эвгүй мэдрэмжүүд өгсөн;

- Өөрийн эрхшээлдээ оруулах;
- Ямар нэгэн чагнах төхөөрөмж, байршил илрүүлэгч гэх мэт;
- Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгих, эсхүл эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан бусдыг мөрдөж мөшгихийг хэлнэ;
- Хуулийн гаргалгаа байдаггүй хохироод үлддэг;
- Мөрдөх эрхгүй этгээдийн хууль бус үйл ажиллагаа, мөн мөрдөх албаны ажилтан эрх хэмжээгээ хэтрүүлэх гэсэн хариултуудыг өгсөн байна.

Тэгвэл хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэгт өртөж байсан гэх зургаан иргэн энэ талаар хууль хяналтын байгууллагад гомдол мэдээлэл гаргаагүй бол нэг иргэнийг гэр бүлийн хамааралтай хүн тул хэргийг шийдвэрлэх боломжгүй, нэг иргэнд гэмт хэрэг биш хэмээн ойлгуулан буцаажээ.

Гэр бүл, хосын харилцааны зөвлөгөө, мэдээлэл бүхий аймаг орон нутгийн зарын мэдээлэл, төрөл бүрийн сэдвээр мэдээлэл солилцох боломжтой зэрэг нийт фэйсбүүкийн зургаан төрлийн хаалттай группийн 35 орчим пост, 1600 гаруй сэтгэгдэл, харилцан ярианд санамсаргүй түүврээр контент анализ хийсэн. Үүнд:

Гар утасны Zenly<sup>11</sup> болон Google, Facebook хэрэглүүрийн байршил заагчийг ашиглан бусдын байгаа газрыг тогтоох, байгаа газар нь очиж сүрдүүлсэн тохиолдол – 16,

Танил талаа ашиглан гар утасны дугаар, гэрийн хаягийг олж мэдсэн тохиолдол – 9,

---

<sup>11</sup> <https://play.google.com/store/apps/details?id=app.zenly.locator&hl=en&gl=US>

Уулзалтын үеэр дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгүүдээс аль нэгийг нь хийсэн тохиолдол – 67,

Хамаатан садан болон найз нөхөд ойр дотнын хүмүүсээс хувийн нууцад хамаарах мэдээлэл цуглуулсан байж болзошгүй тохиолдол – 3,

Хувийн цахим хэрэгслийн нууц үгийг олж авсан, нэвтэрсэн тохиолдол – 42 байна.

Хууль бусаар мөрдөж мөшгисөн байж болзошгүй нийт 137 тохиолдлоос хууль хяналтын байгууллагад гомдол, мэдээлэл өгсөн талаарх сэтгэгдэл тухайн контент анализын явцад нэг ч удаа дурдагдаагүй болно.

Эдгээрээс үзвэл хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн талаарх ойлголт иргэдийн дунд хангалтгүй бөгөөд өөрийгөө энэ гэмт хэргийн хохирогч болж байгааг ч мэдэхгүй байх тохиолдол багагүй байна. Түүнчлэн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх нь хууль зөрчсөн үйлдэл биш гэж үзэх хандлага хууль хяналтын байгууллагад тогтсон байж болзошгүй юм.

## ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 2.1. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БУСДЫГ ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИСӨН ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ<sup>12</sup>

**Хэргийн талаар:** Орхон аймаг дахь цагдаагийн газрын ЭЦТ-ийн эрүүгийн мөрдөгч Г.О нь “... үнэт эдлэлийн дэлгүүрт хулгайч нэвтэрч их хэмжээний алт, монетон эдлэл алдагдсан ...” гэх хэргийг мөрдөн шалгаж байхдаа ЭХХШТХ-ийн 1.8 дугаар зүйлийг зөрчсөн. Үүний улмаас Г.О-д ЭХТА-ийн 20.7, 16.1-д зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж, уг хэргийг АТГ-ын комиссар Ц.М шалгажээ. Харин Г.О нь хэргийг шалгаж байсан мөрдөгч Ц.М-ын эзэмшдэг Мобиком ХХК-ийн \*\*\*\*\* дугаарын орсон, гарсан ярианы мэдээллийг гаргуулан авахаар Мобиком ХХК-ийн Орхон аймаг дахь салбарт албан бичиг хүргүүлж, өөрт нь холбогдох хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан мөрдөгчийг хууль бусаар мөрдөн мөшгиж, ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтуудаас үзвэл шүүгдэгч “эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, хувийн зорилгоор албаны техник хэрэгслийг ашиглан” үйлдсэн болох нь нотлогдож буй бөгөөд энэ нь:

<sup>12</sup> Уг шийдвэрээр хоёр төрлийн гэмт хэрэгт ял оногдуулсан бөгөөд зөвхөн ЭХ-ийн 13.12 дугаар зүйлд хамаарах хэсэгт дүн шинжилгээ хийв.

- хохирогч Ц.М-ын мөрдөн шалгах ажиллагааны явцад өгсөн “ ... Орхон аймаг дахь Мобиком ХХК-ийн салбар дээр очиход ахлах ажилтан Ц.Ц \*\*\*\*\* дугаарын ярианы дэлгэрэнгүй лавлагаа гэх нэг хуудас материалыг өгсөн. Ц.Ц нь надад хандаж “\*\*\*\*\* гэсэн утасны лавлагаа байна, энэ таны лавлагаа мөн үү, доод талд нь таны лавлагаа авч байгаа утасны дугаар байна” гэж хэлээд надад үзүүлсэн. Тэгэхээр нь би лавлагааг авч харахад эрүүгийн 1925001\*\*\*\*\* дугаартай хэргийн яллагдагч Г.О-ын \*\*\*\*\* гэсэн гар утасны дугаар байсан. Би Мобикомын ажилтнаас “лавлагааны доод талд ямар учиртай утасны дугаар бичсэн байгаа”-г лавлахад “энэ бичгийг хариуцаж авах хүнийх нь дугаар байгаа юм аа” гэж тайлбарласан. Энэ лавлагааг хаанаас, хэнээс ирүүлсэн талаар лавлахад цааш бичиг баримтуудыг үзэж байснаа “ийм бичиг ирсэн” гээд гаргаж ирсэн. Дээрх бичигт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 39/03-\*\*\*\*\* дугаартай “...Тус тасгийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.О-т шалгагдаж байгаа 192500051 дугаартай хэрэгт \*\*\*\*\* дугаарын утасны 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хойш орсон, гарсан дуудлага, мессежний дэлгэрэнгүй лавлагааг гарган ирүүлж манай ажилд тусална уу гэж бичсэн байсан... Миний ашигладаг \*\*\*\*\* дугаарын орсон, гарсан ярианы мэдээлэл байсан тул Ц.Ц-аас дээрх лавлагааг би өөрөө аваад өөрийнх нь нэр, албан тушаалыг нь тэмдэглэж аваад явсан ...” гэсэн мэдүүлэг,
- гэрч П.М-ийн мөрдөн шалгах ажиллагааны явцад өгсөн (Орхон аймаг дахь цагдаагийн газрын бичиг хэргийн эрхлэгч) “... Миний бие Орхон аймаг дахь Цагдаагийн газарт бичиг хэргийн эрхлэгч, архивчаар ажилладаг. Ажлын тодорхойлолтод тусгагдсанаар хугацаатай болон хугацаагүй бичгийг бүртгэж, хяналт тавих, даргын өгсөн

*цургийн биелэлтийг тооцох, тушаал, албан бичигт дугаар олгох, архивын хадгаламжийн нэгжийг үүсгэж хадгалах чиг үүрэгтэй. Тухайн өдөр нийт 31 бичгийн дугаар авч холбогдох газарт хүргэгдсэн байна. Уг бичгүүд бүгд л ар хэсэгт хянасан, боловсруулсан хувьтай байна. Харин Г.О-ын дугаар авсан бичгийн архивын нэгжид үлдэх хувийн ар хэсэгт хянасан, боловсруулсан талаарх гарын үсэггүй тул энэ үлдсэн хувь нь архивын нэгжийн шаардлага хангахгүй байна. Тухайн алба хаагч явуулах бичгээ өөрөө боловсруулна ... ” гэсэн мэдүүлэг,*

- гэрч Ц.Ц-ийн мөрдөн шалгах ажиллагааны явцад өгсөн (Мобиком корпорац ХХК-ийн Орхон аймгийн салбарын ахлах ажилтан) “... Цагдаагийн байгууллагаас прокурорын зөвшөөрөлтэй албан бичгийг миний бие хүлээн авч, манайд ирсэн огноо, албан бичгийн дугаар, албан бичгийн хариу гарсан талаарх мэдээлэл өгөх хүний утасны дугаар зэргийг тэмдэглэж авдаг. Тэгэхдээ ямар нэгэн бүртгэлийн дэвтэр байхгүй, файл хэлбэрээр бүртгэдэг. Тэгээд Улаанбаатар хот дахь хуулийн хэлтэс рүү бичгийг хүргүүлдэг. Би утасны дугаарыг нь тэмдэглэж авдаг юм, файлаас харахад \*\*\*\*\* дугаараар холбогдож хариуг өгөх ёстой байсан боловч АТГ-ын алба хаагчид андуурч өгсөн юм ...” гэсэн мэдүүлэг, дахин мэдүүлсэн: “... Мөрдөгч М нь “\*\*\*\*\* дугаарын орсон, гарсан ярианы мэдээлэл миний утасны дугаарынх байна” гэж надаас авсан өдрийн маргааш нь цагдаагийн ажилтан Г.О гэх залуу Ц.М мөрдөгчийн авч явсан \*\*\*\*\* дугаарын орсон гарсан ярианы мэдээллийг авахаар ирсэн. Тэгэхээр нь би Г.О-д \*\*\*\*\* гэх утасны дугаарын эзэн нь ирээд албан бичгийн хариуг аваад явсан” гэж хэлэхэд Г.О албан бичгийн нууцлал алдаж, өгөх ёсгүй хүнд хариу өгч явуулсан байна” гэж уурлаад миний өрөөнөөс гараад явсан....” гэсэн мэдүүлэг,

- гэрч Г.Э-ийн мөрдөн шалгах ажиллагааны явцад өгсөн (Орхон аймаг дахь Цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга) “... Тухайн үед эрүүгийн мөрдөгч Г.О нь дугаарын мэдээллийг авах шаардлагатай талаар л танилцуулж байсан. Дугаарын мэдээллийг авснаар Орхон аймагт хулгайлах гэмт хэрэг үйлддэг хүмүүстэй холбогдсон холболтыг шалгана гэж байсан ...” гэсэн мэдүүлгүүдээр болон хавтаст хэрэгт авагдсан бусад лавлагаа, тэмдэглэлээр Г.О нь ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлд заасан Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байна хэмээн шүүх үзжээ.

### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх уг хэргийг хянаж үзээд шүүгдэгчийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн байдал, улсын яллагчийн ялын санал зэргийг харгалзан үзэж “торгох” ял оногдуулахаар шийдвэрлэсэн байна. Тогтоолд шүүгдэгч Г.О-г ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлд зааснаар өөрт холбогдох хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа мөрдөгчийг хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож тус зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 5400 (таван мянга дөрвөн зуу) нэгжтэй тэмцэх хэмжээний төгрөгөөр торгох ялаар шийтгэж шийдвэрлэсэн.

### **Дүн шинжилгээ**

Шүүхийн шийдвэрийн цахим санд ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийдвэрлэсэн хэрэг нэг байна. Уг хэргийг 2020 онд эрүүгийн мөрдөгч албан тушаалтай этгээд үйлдсэн бөгөөд шүүхээс түүнд тухайн хуулийн санкцын хамгийн бага хэмжээгээр ял оногдуулжээ. Мөрдөн шалгах эрх бүхий этгээд хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрх хасах ял оногдуулах санкц байхгүй боловч тухайн гэмт хэрэг үйлдсэн

этгээдийн хувийн байдал, нийгэмд учруулж буй аюулын хэмжээ зэргийг харгалзан үзвэл тухайн этгээд эрхэлж буй албан тушаалаа үргэлжлүүлэн эрхлэх боломжтой байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүй, эрүүгийн хариуцлага хөнгөдсөн гэж үзэх үндэслэлтэй юм. Хэдийгээр эрхэлж буй албан тушаалаас чөлөөлөх эсэх нь тухайн этгээдийн ажиллаж буй байгууллагаас хуульд заасны дагуу гаргах шийдвэр боловч шүүхээс тухайн хэргийн нийгмийн аюулын шинж чанарыг харгалзан үзэж ял оногдуулах боломжтой байсан гэж үзэж байна.



## 2.2. БУСДЫН ЗАХИАЛГААР ИРГЭНИЙГ МӨРДӨЖ МӨШГИСӨН ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэргийн талаар:** Шүүгдэгч А.Т нь иргэн Б.Д-г 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “...” фитнес, Толгойтын Их Нарангийн 65 дугаар сургуулийн гэр хороолол, автобусны буудал зэрэг газраар дагаж, 2020 оны 02 дугаар сарын 09-ний өдөр мөн Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр ... хороололд байрлах “...” ресторанд бусадтай уулзаж байх үед нь зургийг нь дарж, ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтуудаас үзвэл шүүгдэгч “мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөж мөшгисөн” гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдож байх бөгөөд энэ нь:

- шүүгдэгч А.Т-ийн “ ... буруу үйлдэл хийсэндээ харамсаж байна ...”, “... 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Унгар Улсад оршин сууж байгаа Б гэдэг залуу ... гэсэн хаягнаас салсан эхнэрээ мөрдцүлэх гээд над руу чат бичсэн. Тухайн үед би тэр залуутай хөлс мөнгөө тохироод эхнэрийнх нь машины дугаар, гэрийн хаяг, явдаг фитнес зэргийг заалгуулж аваад салсан эхнэр Б.Д гэх эмэгтэйд 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутагт үйл ажиллагаа явуулдаг Могол

*фитнес, Толгойтын Их Нарангийн 65 дугаар сургуулийн гэр хороолол, автобусны буудал зэрэг газраар дагасан. Маргааш нь 2020 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Содон хороололд Brown house нэртэй цйлчилгээний газруудаар дагаж зургийг нь авч Б-ын ... гэсэн хаяг руу явуулсан ...*” гэсэн мэдүүлэг болон гэрч, хохирогчийн мэдүүлгээр А.Т нь ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлд заасан Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байна хэмээн шүүх үзжээ.

### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс уг хэргийг хянаж үзээд ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, ЭХЕА-ийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасныг журамлан А.Т-г Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хорих ялыг оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэх, Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалтад заасан “зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах” үүрэг, хязгаарлалтыг хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд тогтоох шийдвэрийг гаргасан байна. Шүүх уг хэргийн хууль зүйн дүгнэлтэд шүүгдэгч А.Т нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй байж, хялбар аргаар мөнгө олох зорилгоор, **шууд санаатай үйлдлээр** хохирогч Б.Д-ыг мөрдсөн нь “мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөж мөшгисөн” гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан хэмээн үзсэн.

Харин давж заалдах шатны шүүхээс “Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 2021/ШЦТ/284 дугаартай шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “Шүүгдэгч А.Т-г холбогдох Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан

хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад зааснаар хэрэгсэхгүй болгож, А.Т-г хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнссэн ялаас чөлөөлсүгэй” гэсэн нэмэлт заалт оруулж шийдвэрлэсэн нь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой бөгөөд гэмт хэрэг үйлдсэн гэм буруугийн хувьд маргаангүй байна.

### **Дүн шинжилгээ**

Тухайн шүүхийн шийдвэрийн хууль зүйн дүгнэлтэд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийн зорилгод үндэслэн гэм буруугийн хэлбэрийг тогтоосноороо онцлог байна. Тухайлбал, тухайн шийдвэрт энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ хялбар аргаар мөнгө олох зорилго агуулсныг онцлоод ЭХ-ийн Ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлд заасан Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэхээр шийдвэрлэсэн нь цаашид ижил төстэй үйлдэл бүхий гэмт хэрэгт ашиглаж болохуйц практик болсон байна.

### 2.3. БУСДЫН ГЭРИЙН ХАЯГ, УТСЫГ ОЛЖ АВАХААР ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИСӨН ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэргийн талаар:** Шүүгдэгч Б.Б нь өмнө ажиллаж байсан сургуулийн тэнхимийн эрхлэгч Н.Б-ийн гэрийн хаяг, гар утасны дугаарыг олж авахаар шүүгдэгч П.С-д төлбөр төлж, бүлэглэн ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтуудаас үзвэл шүүгдэгч “мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөж мөшгисөн” гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдож буй бөгөөд энэ нь:

- гэрч Н.Б-ийн “... 2018 оны 10 дугаар сараас олон нийтийн сүлжээ фэйсбүжк, МУИС-ийн эмэйл хаяг, сургуулийн бусад багш нар, сургуулийн удирдлага, БСШУЯ-ны сайдад хүртэл миний талаар худал гүтгэлэг мэдээг системтэй, үе шаттайгаар 2019 оны 04 дүгээр сарыг дуустал тарааж, сэтгэл зүйн дарамт учруулсан. Мөн цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн нэрийг барьж хуурамч эмэйл хаягаар удаа дараа мэйл илгээж байсан. 2019 оны 03 дугаар сарын сүцлээр манай гэрийн хаалгыг хөшиж эвдсэн. Түцний дараа 04 дүгээр сарын 05-ны өдөр үл таних хоёр этгээд шөнийн цагаар нүүрээ далдалж хар маск зүүсэн хоёр хүн гэрт ирж Н.Б мөн үү гэж хаалга нүдэж онгойлгохыг шаардсан. Яах гэж байгаа

талаар асуухад “СӨХ-оос явж байна. Судалгаа авах гэсэн юм” гэж хэлсэн. Түцүнээс гадна миний утас руу танихгүй дугаараас уулзъя гэж дандаа оройн цагаар мессеж бичиж, “ Багш аа, тантай уулзъя. Ярих юм байна. Цэцэг хүргэлт байна” гэх мэтээр янз бүрээр залгах, мессеж бичих зэргээр дарамтлах болсон ...” гэсэн мэдүүлэг, хохирогчоос авсан мэдүүлэгт “... Би урьд нь мэдцүлэгтээ тодорхой дэлгэрэнгүй мэдцүлсэн. Миний талаар худал мэдээлэл олон нийтэд тараасан, сэтгэл санааны хохирол болон хаалга эвдэж, эд хөрөнгийн хохирол учруулсан этгээдийг олж тогтоож, хуулийн дагуу хариуцлага хцлээлгэмээр байна ...” гэсэн мэдүүлэг;

- гэрч Г.Э-н “ ... 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ... гэх нэртэй фэйсбүцкээр надтай харилцаад эхлээд нэг юмны төлбөр хийх гэсэн юм гэж хэлээд 25,000 төгрөг, миний Япон улсаас машины сэлбэг авдаг данс руу 1577 иенийг шилжцүлсэн. Түцүний оронд би 25,000 төгрөгийг түцүний надад хэлсэн Хаан банкны ... тоот данс руу шилжцүлсэн. Дараа өдөр нь буюу 03 дугаар сарын 11-ний өдөр 175 иенийг Япон улсаас сэлбэг авдаг данс руу шилжцүлээд намайг Худалдаа хөгжлийн банкны ... тоот П.С гэдэг данс руу 40,000 төгрөгийг шилжцүлчих гэж хэлсэн. Тэр хүн мөнгөө шилжцүлсэн баримтаа фэйсбүцкээр шилжцүлээд би Монгол данс руу түцүний хэлсэн мөнгөнцүдийг шилжцүлж байсан. Япон улсаас сэлбэг авдаг манай найз данс руу мөнгийг шилжцүлж авч байсан ...” гэсэн мэдүүлэг;
- гэрч Б.Б-н “... Миний санаж байгаагаар 2019 оны 03 дугаар сарын эхээр нөхөр бид хоёр фэйсбүцкийн Цагийн ажил гэх группээс өндөрцалинтай, цагийн ажилд хүн авна гэсэн зарыг олж хараад ... гэх хаяг руу чат бичиж холбогдсон. Манай нөхөр П.С миний ... гэсэн хаягаар тэр хүнтэй холбогдсон.

*Би юу бичиж байгааг нөхрөөсөө сонсдог байсан. Нөхөр надад хэлэхдээ “Энэ хүн нэг багшийг мөрдцүлээд гэрийн хаягийг нь мэдэж чадах юм бол 500,000 төгрөг, гар утсыг нь аваад өгөх юм бол 2,000,000 төгрөг өгнө” гэж хэлсэн. Тухайн үед би өөрийн 9\*\*\*\*\*8 дугаарыг андройд үйлдлийн системтэй, ухаалаг гар утсанд хийж ашигладаг байсан. Нөхөр болохоор товчлууртай Нокиа маркийн гар утас ашиглаж байсан. Тэгээд тэр хүнтэй чатаар харилцаж байхын тулд миний гар утсыг аваад явсан. Фэйсбүжкийн ... гэх хаягтай хүн манай хүнтэй чатаар харилцаж, тэр багшийг хаана суудаг, хэдэн давхарт байдаг гээд хувийн мэдээллийг нь хэлж өгсөн байсан. Би нөхрөөсөө гэртээ ирэхэд нь юу болсон талаар сонсож мэддэг байсан. Миний хувьд хүчхдээ хараад гэртээ үлддэг байсан. Нөхөр надад хэлэхдээ хоёр хоног тэр багшийг дагасан. Тэр багш нь нэг бол номын санд ороод гарч ирдэггүй, эсхүл найз нартайгаа ч юм уу машинд суугаад явчихдаг гэсэн. Манай нөхөр машингүй болохоор араас нь такси бариад явах гэсэн ч мөнгөгүй учир ажлаас нь гарахаар л алдчихдаг гэсэн. Би сүүлдээ нөхөртөө хандаж “Наадах чинь худлаа юм биш үү, боль” гэж хэлдэг байсан ...” гэсэн мэдүүлгүүд болон хавтаст хэрэгт авагдсан бусад лавлагаа, тэмдэглэлээр П.С, Б.Б нар нь бүлэглэн ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлд заасан Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байна хэмээн шүүх үзжээ.*

### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Тухайн хэрэгт нийт гурван шүүхийн шийдвэр байх бөгөөд анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хоёр, давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэсэн нэг шийдвэр байна. Үүнд:

- Анхан шатны шүүхийн 2021/ШЦТ/566 дугаартай шийдвэрээр шүүгдэгч Б.Б, П.С нарыг бүлэглэн мөрдөн

шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох үндэслэлтэй гэж үзсэн боловч шүүгдэгч Б.Б, П.С нар нь ЭХТА-ийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг үйлдсэн, 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр яллагдагчаар татсан. Тэдний үйлдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хөнгөн гэмт хэргийн ангилалд хамаарч байна. Эрүүгийн хуулийн (2017 онд Эрүүгийн хуульд орсон өөрчлөлтөөр) 1.10 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн ” гэж, мөн хуулийн 2-д “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно” гэж хуульчилсан бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь хүчингүй болсон тул шүүгдэгч Б.Б, П.С нарт холбогдох хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

- Харин шүүгдэгч Б.Б давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбарт: *“... Миний холбогдсон хэргийн хүрээнд дурдагдаж байгаа үйлдлүүд маань Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мөрдөж мөшгих” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаагүйгээс гадна гэмт хэргийн шинжтэй үйлдэл огт биш юм. Гэтэл анхан шатны шүүх хэргийн үйл баримтыг буруу үнэлж дүгнэн, хуулийг*

*буруу тайлбарлан хэрэглэж намайг Эрцүгийн хуулийн тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хууль бусаар мөрдөн мөшгих” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай хэмээн дүгнэсэн нь дараах байдлаар үндэслэлгүй байна.*

*Эрцүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мөрдөн мөшгих” гэмт хэргийн диспозид “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн бол...” хэмээн тусгасан бөгөөд “мөрдөх” гэх ойлголт нь дээрх заалт дахь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн хийдэг аливаа этгээдийг дагах, мөшгих, тагнах шинжтэй “идэвхтэй үйлдэл” юм. Гэтэл шийтгэх тогтоолынхоо үндэслэх хэсэгт дурдсан гэрч Б.Б-н “...тэр багш нь нэг бол номын санд ороод гарч ирдэггүй, эсхүл найз нартайгаа ч юм уу машинд суугаад явчихдаг гэсэн. Манай нөхөр машингүй болохоор араас нь такси бариад явах гэсэн ч мөнгөгүй учир ажлаас нь гарахаар л алдчихдаг гэсэн..., ...нөхөр ямар ч байсан хоёр өдөр МУИС дээр очиж тэр багшийг дагасан” гэх мэдүүлэг (1xx 67-71), шүүгдэгч П.С-ын “...гарч иртэл нь хүлээж бай, оройтвол таксинь мөнгө явуулъя гэхэд нь автобус зогсох гээд байсан учир яваад өгсөн, маргааш нь такси бариад дагах ёстой байсан боловч хүлээж байгаад орой болохоор нь гэр лүцгээ явсан, би Н.Б багшийг сургууль дээр нь очиж гурван удаа дагасан боловч машинд суухаар нь алдсан” (1xx 227-235) гэх мэдүүлгүүдээс үзэхэд шүүгдэгч П.С нь хохирогч гэх Н.Б-г дагасан, мөрдөж мөшгисөн идэвхтэй үйлдэл огт байхгүй байна. Учир нь П.С-ын дээрх үйлдлүүд нь Н.Б-г дагасан, мөрдөж мөшгисөн идэвхтэй үйлдэл бус зөвхөн түүний ажлын байрны гадаа хүлээж суусан, гарч ирэхгүй оройтох цед нь барааг нь ч харж чадалгүй буцсан, эсхүл ажлаасаа гараад машинд суугаад явахад нь араас нь дагах, мөрдөн мөшгих боломжгүй учраас гэр лүцгээ харьсан. Түүнчлэн Эрцүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх*



хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал буюу үйлдэл нь мөрдөн мөшигсөн идэвхтэй мөрдөн шалгах эрхтэй этгээдийн хийдэг үйлдэл байх ёстой. Агуулгын хувьд энэ нь бусдыг тусгай мөрдлөгийн багаж хэрэгсэл ашиглан мөрдөх буюу хууль тогтоогчийн бодлогын үүднээс “хувийн мөрдөгч” гэх этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах зорилгоор хуульд шинээр оруулж ирсэн заалт юм. Гэтэл анхан шатны шүүх ямар үндэслэлээр тус гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдсан гэж үзсэнээ шүүхийн шийдвэрт тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, Н.Б-г ажлаасаа гараад хаа нэг тийшээ явахад нь холоос харсан, очсон газрыг нь олж мэдсэн зүйл байхгүй буюу дагах оролдлого ч хийгээгүй, тийм боломж ч байгаагүй аж. Гэтэл анхан шатны шүүх П.С-ын үйлдэлд ямар нэгэн мөрдөн мөшигсөн шинжтэй идэвхтэй үйлдэл байхгүй байхад мөрдөн мөшигсөн, харин намайг мөрдөн мөшигх гэмт хэрэгт хатгагчаар оролцсон гэж дүгнэсэн нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, хоёрдугаарт шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцэхгүй байх тул шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож өгнө үү ...”;

- шүүгдэгч Б.Б-н өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбарт “ ... Гэрч Н.Б-н мэдүүлэгт өөрийг нь дагасан гэх хүнийг харсан талаар нэг ч удаа мэдүүлээгүй байдаг. Мөн бодит ямар хохирол учирсан талаар хохирогчоор тогтоосон мэдүүлэгт мэдүүлээгүй байна. Тус хэргийн бодит байдлыг мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоож чадаагүй, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив болон субъектив талыг хангаагүй байна.
- Мөрдөн мөшигх ажиллагаа гэдгийг мөрдөн байцаалтын явцад тогтоогоогүй, яг ямар мөрдөн шалгах ажиллагаа

явуулсан нь тодорхойгүй байхад гэм буруутайд тооцсон нь хэргийн бодит байдалтай нийцэхгүй, эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж байна. Хууль бусаар мөрдөн мөшигх гэж юуг ойлгоод байгааг тодорхойлоогүй, ямар төрлийн мөрдөн мөшигх ажиллагаа байсан нь гэрчүүдийн мэдүцлэг, бусад нотлох баримтаар нотлогдохгүй байхад нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл гэж шүүхээс дүгнэсэн нь хуульд нийцээгүй байна.

- Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хууль бусаар мөрдөж мөшигх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангаагүй бол гэмт хэрэг биш байхаар хуульчилсан байдаг. Харин Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал буюу үйлдэл нь мөрдөн мөшигсөн идэвхтэй мөрдөн шалгах эрхтэй этгээдийн хийдэг үйлдэл байх ёстой. Агуулгын хувьд энэ нь бусдыг тусгай мөрдлөгийн багаж хэрэгсэл ашиглан мөрдөх буюу хууль тогтоогчийн бодлогын үүднээс хувийн мөрдөгч гэх этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах зорилгоор хуульд шинээр оруулж ирсэн заалт юм. Гэтэл анхан шатны шүүх ямар үндэслэлээр тус гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагдсан гэж үзсэнээ шүүхийн шийдвэрт тусгаагүй байна ...” гэж тус тус үзэн “... Иймд гэмт хэргийн бүрэлдэхүүн тогтоогдоогүй байхад гэм буруутай гэж анхан шатны шүүхээс дүгнэсэн нь хуульд нийцэхгүй байгаа тул шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгож өгнө үү ...” хэмээн хүсэлт гаргажээ.
- Харин давж заалдах шатны шүүхийн 2021/ДШМ/937 дугаартай шийдвэрээр “Анхан шатны шүүх, шүүгдэгч П.С, Б.Б нарыг бүлэглэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшигсөн гэмт хэрэг үйлдсэн

гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1, 1.2, Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1, 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан прокуророос Б.Б-д Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 3.1, 3.4 дэх хэсгийг журамлан Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 3.1, 3.2 дахь хэсгийг журамлан Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар П.С нарт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй, Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байна”, “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэж өөрчилсөн бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолохоор заасан өмнөх хуулийн зохицуулалтыг буцаан хэрэглэх хууль зүйн үндэслэлгүй тул шүүгдэгч П.С, Б.Б нарыг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх боломжгүй юм.

- Түүнчлэн Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг тогтоосон зохицуулалт нь хэдийгээр материаллаг хуульд тусгагдсан боловч зохицуулж байгаа харилцааны мөн чанар, агуулгын хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны буюу процессын шинжийг илэрхийлдэг тул хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолохоор тогтоосон хуулийг баримтлах

*нь зүйтэй. Иймд шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.” хэмээн хууль зүйн дүгнэлт гаргажээ.*

- Мөн анхан шатны шүүхийн 2021/ШЦТ/392 дугаартай шийдвэрээр “Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшигсөн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан бөгөөд уг гэмт хэрэгт оногдуулахаар хуульчлан тогтоосон ялаас дараах нөхцөл байдлуудыг харгалзан үзсэний үндсэн дээр шүүгдэгчид оногдуулах эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэлтэй гэж шүүх үзэв. Үүнд:

- o Шүүгдэгч нарт ял шийтгэл оногдуулахад Б.Б нь анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, П.С-ын үйлдэлд ял хөнгөрүүлэх нөхцөл байдал, тэдгээрийн үйлдэлд Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 6.6-д заасан ял хүндрүүлэх нөхцөл байдал тус тус тогтоогдоогүй болно.

- Шүүгдэгч Б.Б нь урьд ял шийтгүүлж байгаагүй, П.С нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, шүүгдэгч нар нь бусдад төлөх төлбөргүй, Б.Б нь дээрх хэргийг санаачлан улмаар П.С-ыг татан оролцуулсан, дээрх гэмт хэргийн улмаас П.С нь 61 хоног цагдан хоригдсон, тэдгээрийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг тал бүрээс нь харгалзан үзэж эрүүгийн ял шийтгэлийн үр нөлөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулахад

чиглэж, Эрцүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрөл, хэмжээний дотор Б.Б-д есөн сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял, шүцүгдэгч П.С-д долоон сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял тус тус оногдуулахаар шийдвэрлэв.

- Шүцүгдэгч П.С-ын үйлдсэн гэмт хэрэг нь 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн Монгол Улсын Өршөөл үзүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт заасан хууль үйлчлэх цаг хугацаанд буюу “2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 24 цаг 00 минутаас өмнө 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрцүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн”-д хамаарч байх бөгөөд мөн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт зааснаар өршөөлд хамаарч байх тул шүцүгдэгч П.С-ын Эрцүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан долоон сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялыг өршөөн хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.
- Өршөөл үзүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг үйлдсэн яллагдагч мөрдөн байцаалтын шатанд гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, энэ хуулийн 4.2-т заасан шаардлагыг хангаж байгаа бол эрцүгийн хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгоно” гэж зааснаар шүцүгдэгч Б.Б нь өөрийн гэм буруугаа хүлээн зөвшөөрөөгүй байх тул дээрх шаардлагыг хангаагүй гэж үзэж Өршөөл үзүүлэх тухай хуульд хамруулах боломжгүй юм” хэмээн дүгнэж, хэргийг шийдвэрлэжээ.

Тус шүүхээс “Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэрэг нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн нийгэмд аюултай

гэм буруутай үйлдэл байхыг хуульчилсан бөгөөд **мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисөн идэвхтэй үйлдэл байх ба бусдыг мөрдөн мөшгисөн үеэс төгсдөг, хор уршиг учирсан байхыг шаарддаггүй, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болно.**

Шүүгдэгч Б.Б-г их сургуульд ажиллах шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарсны дагуу 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс түүнтэй байгуулсан гэрээг дуусгавар болгосонтой холбоотойгоор Н.Б-н **халдашгүй чөлөөтэй байх эрхэд халдаж, түүний гар утсыг авах, гэрийг нь мэдэх зорилгоор П.С-ыг хөлсөлж, тодорхой мөнгө өгөхөөр амлан, Н.Б-н ажлын хаяг, утасны дугаар, өрөөний дугаар, зураг зэргийг өгч, дээрх ажлыг гүйцэтгүүлэхээр 60,000 төгрөгийг шилжүүлж, дээрх үйлдэл нь хууль бус болохыг мэдсээр байж, түүнийг хүсэж санаатай үйлдсэн байна”** гэсэн дүгнэлтийг гаргажээ.

### **Дүн шинжилгээ**

Энэхүү шүүхийн шийдвэрт хүний эрхийн суурь ойлголтыг хөндөн хууль зүйн дүгнэлт гаргасан нь ач холбогдолтой байх төдийгүй тус гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэдгийг тодорхойлж, санаатай үйлдлийн шинжийг дэлгэрүүлэн тайлбарласан нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход тустай байна. Мөн хүний хувийн болон орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн уг гэмт хэргийн гэм бурууг тодорхойлохдоо “бүлэглэн” үйлдсэн гэж үзээд бусдыг мөрдөж мөшгүүлэхээр мөнгө төлсөн этгээдэд хариуцлага оногдуулсан байна.

#### 2.4. БУСДЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД БАЙРШИЛ ТОДОРХОЙЛОХ, ЧАГНАХ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАН МӨШГИСӨН ТУХАЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэргийн талаар:** Шүүгдэгч М.Д нь З.Б-н эзэмшлийн “Тоёота Приус” маркийн автомашинд хөдөлгөөнт байршил тодорхойлогч, чагнах төхөөрөмж суурилуулж, уг төхөөрөмжөө ашиглан 2021 оны 03 дугаар сараас 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд яриаг нь чагнах, Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Зайсан стар худалдааны төвөөс хохирогч З.Б-г Хан-Уул дүүргийн 17 дугаар хороо, “К” хотхонд байх гэртээ очтол нь дагах зэргээр ЭХ-ийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлд заасан Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байна хэмээн шүүх үзжээ (Анхан шатны шийдвэрт зөвхөн тогтоох хэсэг нийтлэгдсэн).

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судалсан нотлох баримтуудаас үзвэл шүүгдэгч “мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөж мөшгисөн” гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдож байх бөгөөд энэ нь:

- хохирогч З.Б-н “ ... 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр намайг ажил дээрээ байхад М.Д манай ажил дээр орж ирээд тухайн өдөр би машинаа бариад явж байхдаа найзтайгаа утсаар ярьсан яриаг маань сонсчихсон мэт “Чи өөр хүнтэй уулзаад байгаа юм уу” гэх мэтчилэн манай ажил дээр хэрцүл маргаан үүсгэсэн. Тэгээд би М.Д-г ямар нэгэн

байдлаар миний утсаар ярьсан яриаг сонсчихлоо гэдгийг олж мэдээд 2021 оны 12 дугаар сарын эхээр Л гэх дүцгээрээ ажлынхаа гадна машин дотор ямар нэгэн төхөөрөмж байна уу, үзээд өгөөч гээд үзүцлэхэд жолооны хүрдэн доорх залгуурт дөрвөлжин хар өнгийн хуванцар гадаргуутай зүйлийг залгасан байсныг олж салгуулсан. Д-тэй утсаар холбогдож уурлахад ямар нэгэн зүйл хэлээгүй...” гэсэн мэдүүлэг;

- гэрч И.Л-н “ ... М.Д “Чи муу намайг юу гэж ярьдаг гэнэ ээ” гэх зэргээр ярьсан яриаг маань мэдэж байна гэж Б хэлэхээр нь би машиных нь тцлхцүрийг аваад машиныг нь шалгаж үзэхэд жолооны хүрдний доод талын компьютер оношилгоо хийхэд ашигладаг залгуурт дөрвөлжин хар өнгийн зүйл залгачихсан байсан. Тухайн эд зүйл дээр цэнхэр өнгийн гэрэл анивчаад байхаар нь салгаж аваад З.Б эгчид өгсөн. Гэтэл З.Б эгч гэртээ очоод тэр зүйлийг онгойлгож үзэхэд сим карт гарч ирж байна гэж надад утсаар хэлж байсан. ... З.Б эгч тухайн төхөөрөмж хаана байсныг огт мэдэхгүй байсан учраас намайг машиныг нь үзэж өгөхийг гуйсан. ...Миний хувьд З.Б эгч М.Д хоёрын дундах харилцааны талаар сайн мэдэхгүй. ...” гэсэн мэдүүлэг;
- шинжээч Д.Мөнхбаатарын “... Уг төхөөрөмжид гар утасны дугаартай сим карт хийж тухайн дугаар луу өөр утаснаас залгасан тохиолдолд ойр орчмын яриаг сонсох боломжтой. Харин уг төхөөрөмж нь өөр дээрээ мэдээлэл хадгалах, санах ой байхгүй зөвхөн дуудлагын явцад ойр орчмын яриа, чимээ шуугианыг сонсох зориулалт бүхий төхөөрөмж байна. ... Тусгай төхөөрөмж гэж ойлгож болно. ...” гэсэн дүгнэлт;



- шүүгдэгч М.Д-н яллагдагчаар өгсөн “ ... Би тухайн эд зүйлийг 2021 оны 4, 5 дугаар сарын цед фэйсбүцк хуудсан дээр автомашины дохиолол, GPS зарна гэсэн зарын дагуу нэг хүнтэй утсаар холбогдоод 10 дугаар хороололд очиж 40,000-60,000 төгрөгийн хооронд худалдаж авч байсан санагдаж байна. ...” гэсэн мэдүүлгүүд болон хавтаст хэрэгт авагдсан бусад лавлагаа, тэмдэглэл, дүгнэлтээр М.Д нь ЭХ-ийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлд заасан Хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдож байна хэмээн шүүх үзжээ.

### **Хэргийг шийдвэрлэсэн байдал:**

Уг хэргийг анхан шатны шүүхээс шүүгдэгч А овогт М-ын Д-г Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч М.Д-г арван сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэсэн.

Харин Давж заалдах шатны шүүх шүүгдэгч М.Д-н гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгисэн хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх хуульд заасан нөхцөлүүдийг харгалзан үзэж тухайн зүйл, хэсэгт зааснаар арван сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж шийдвэрлэснийг өөрчлөх, эсхүл буруутган дүгнэх хууль зүйн үндэслэл тогтоогдоогүйгээс гадна, Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийг хэрэглэх шаардлагагүй, Эрүүгийн хуулийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх, цээрлүүлэх зорилгод оногдуулсан ялын хэмжээ нь нийцсэн байна. Иймд шүүгдэгч М.Д-н гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны

шүүхийн 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 319 дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэж шийдвэрлэсэн. Хэргийн дүгнэлтэд “хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн, анхан шатны шүүх хуралдааны хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар хөдөлбөргүй нотлогдон тогтоогдсон” бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно” гэсний дагуу анхан шатны шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцох эрх бүхий яллах болон өмгөөлөх талуудыг оролцуулан, хуульд заасан үндэслэл журмын дагуу тэдний тайлбар, дүгнэлт, шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн шүүхээс шүүгдэгч М.Д-г Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон нь хэргийн бодит байдалтай нийцсэн хэмээжээ.

### **Дүн шинжилгээ**

Энэ шийдвэрийн хувьд шүүгдэгч нь давж заалдах шатны шүүхэд ял хөнгөрүүлэхээр хүсэлт гаргасныг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ. Уг шийдвэрт “Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заажээ. Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан шүүх дараах байдлаар хорих ялыг хөнгөрүүлж, ялаас чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэсэн заалт нь заавал хэрэглэх заалт биш юм” хэмээн тодотгосон нь шүүх дан ганц үйлдсэн

хэргээ хүлээн зөвшөөрсөн, хохиролгүй, хохирогч гомдолгүй гэх мэт шалтгаанаар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээг оногдуулдаг гэсэн ойлголтыг халахад тус болох практик болсон ажээ.



## ДҮГНЭЛТ

Шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдийн гэмт хэрэгт холбогдсон шалтгаан, шинжлэн судлах шаардлагатай нотлох баримтуудыг үндэслэн энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх шүүхийн практикийг амжилттай тогтоож байна гэж үзэж болохоор байна. Үүний дотор хувь хүний эрх, эрх чөлөөнд халдаж үйлдсэн гэмт хэргийг шийдвэрлэхдээ “бусадтай бүлэглэж”, “нийгмийн аюулын хэмжээ болон бусад байдлыг харгалзан ял хөнгөрүүлэх үндэслэлгүй” зэрэг дүгнэлтийг гаргаж байгаа нь шүүхийн практикт хүний суурь эрхэд хүндэтгэлтэй хандаж байгааг харуулж байна.

Шүүхийн шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээний агуулгаар дүгнэн харвал “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна”, “Хүний хувийн болон орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн уг гэмт хэргийн гэм бурууг тодорхойлохдоо “бүлэглэн” үйлдсэн гэж үзээд бусдыг мөрдөж мөшгихөөр мөнгө төлсөн этгээдэд хариуцлага оногдуулсан”, “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зорилго, гэм буруугийн хэлбэрийг онцолж өгсөн бөгөөд тухайн шийдвэрт энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ хялбар аргаар мөнгө олох зорилго агуулсныг дахин онцлоод ЭХ-ийн Ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлд заасан Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хэрэглэхээр шийдвэрлэсэн” зэрэг цаашид практикт хэрэгжүүлэхдээ жишиг болгон ашиглаж болох сайн шийдвэрүүд байгааг онцолж буй юм.

Мөрдөн шалгах эрх бүхий этгээд хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрх хасах ял оногдуулах санкц байхгүй боловч тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, нийгэмд учруулж буй аюулын хэмжээ зэргийг харгалзан үзвэл тухайн этгээд эрхэлж буй албан тушаалаа үргэлжлүүлэн эрхлэх нь зүйд нийцэх эсэх нь эргэлзээтэй байна. Шүүхийн шийдвэрийн цахим санд ЭХ-ийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээр шийдвэрлэсэн хэрэг ердөө **нэг** байна. Цаашид энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн Мөрдөн шалгах эрх бүхий этгээдэд оногдуулах ялын бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах эрх бүхий этгээд энэ гэмт хэргийг үйлдэж байгаа нь нийгмийн аюулын хувьд харьцангуй их бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд тухайн албан тушаалыг үргэлжлүүлэн эрхлэх нь зүйд нийцэхгүй юм.

Гэмт хэргийн гомдол мэдээлэлд бүртгэгдээгүй, шүүхээр шийдэгдээгүй боловч хууль бусаар мөрдөж мөшгих тохиолдол байсаар байгаа бөгөөд ялангуяа цахим орчинд ихээр үйлдэгддэг энэхүү гэмт хэрэг нуугдмал түвшинд байна. Түүнчлэн нийгэмд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс нэгнээ мөрдөж мөшгих нь гэмт хэрэг биш гэж дүгнэж, зарим тохиолдолд хууль хяналтын байгууллагаас энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдолд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэж байна. Иймд дээрх асуудалтай холбоотойгоор тухайн гэмт хэрэгт тайлбар нэмж оруулах шаардлагатай гэж үзэв.

Иргэд, олон нийтийн дунд хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж буйгаа мэдэхгүй байгаа нь нуугдмал гэмт хэргийн тоо өсөхөд шууд нөлөөлж, энэ нь цаашлаад хүнийг хууль бусаар мөрдөж мөшгих гэмт хэрэг нийгэмд хэвийн үзэгдэл мэт ойлгогдоход хүргэж байна.

## САНАЛ

“Хууль бусаар мөрдөж мөшгих” гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнд үндэслэн дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлээд зургаан жил өнгөрсөн боловч анхан шатны шүүхээр хэлэлцэж шийдвэрлэсэн хэрэг ердөө тав байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байгааг харуулж байгаа бөгөөд шүүхээс шийдсэн хэргийн талаар нээлттэй мэдээлэл өгч, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, энэ нь цаашлаад бусдыг “хууль бусаар мөрдөж мөшгих” нь гэмт хэрэг мөн гэдгийг ухамсарлахад ач холбогдолтой байна;
- Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь мэдээллийн зөрүүтэй байдал нь шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх явцад хэд хэдэн удаа давтагдсан. Иймд шүүхийн тамгын газраас цахим санд оруулсан шүүхийн шийдвэрээ эргэж хянах, тухайн зүйлчлэлд хамаарахгүй өөр хэргийн материал оруулсан бол даруй засах зэрэг арга хэмжээг тогтмол авч байх шаардлагатай.
- Хэдийгээр шүүхийн шийдвэр нь ил тод байх ёстой боловч хэргийн оролцогчдын регистрийн дугаар, утасны дугаар зэрэг хувийн мэдээллийг нууцалж хэвших шаардлагатай.
- Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 13.12 дугаар зүйлд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс нэгнээ мөрдөж мөшгих нь тухайн гэмт хэргийн субъектэд хамаарах талаар тайлбар нэмж оруулах нь зүйтэй гэж үзлээ.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Шүүхийн шийдвэрүүд

- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал:
  - 2021/ДШМ/604
  - 2021/ДШМ/937
  - 2022/ДШМ/715
- Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр:
  - 2021/ШЦТ/284
- Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр:
  - 2020/ШЦТ/277
- Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр:
  - 2021/ШЦТ/392
  - 2021/ШЦТ/566
- Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр:
  - 2022/ШЦТ/319

### **Эрх зүйн баримт бичиг**

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966.
- Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015.
- Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017.
- Австрали улсын Квийнсланд мужийн Эрүүгийн хууль.
- ОХУ-ын Эрүүгийн хууль.

### **Эрдэм шинжилгээний бүтээл**

- Б.Энхболд, “Монгол Улс дахь нуугдмал гэмт явдлын түвшинг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаагаар тооцсон байдал”, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл №1(67), 2016.

### **Цахим эх сурвалж**

- "Уголовный кодекс Российской Федерации" от 13.06.1996 N 63-ФЗ (ред. от 14.07.2022, с изм. от 18.07.2022) (с изм. и доп., вступ. в силу с 25.07.2022) [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_10699/4234a27af714cc608ea71b7bae9400f3613c8f60/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_10699/4234a27af714cc608ea71b7bae9400f3613c8f60/)
- [http://classic.austlii.edu.au/au/legis/qld/consol\\_act/cc189994/s359b.html#unlawful\\_stalking](http://classic.austlii.edu.au/au/legis/qld/consol_act/cc189994/s359b.html#unlawful_stalking)
- <https://mongoltoli.mn/dictionary/detail/58315>
- <https://police.gov.mn/>
- <https://shuukh.mn/>



# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M.)  
GREEN CLIMATE FUND, АХЛАХ ХУУЛЬЧ



Д.Золжаргал нь Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. ОУ-ын байгууллагад уригдан ажиллахаасаа өмнө монголын томоохон арилжааны банк, бүс нутагт хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх хуулийн фирм байгуулж ажилласан туршлагатай.

МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалавр, 2004 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН СУДЛААЧ



С.Билгүүн нь хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд суралцаж, “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон улсын Кьюсюгийн их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ХУУЛЬ БУСААР МӨРДӨЖ МӨШГИХ ГЭМТ ХЭРГИЙН  
ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН



Н.Отгончимэг нь Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын тамгын газар, Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх хийх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оноос УДШ-ийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг Магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг Хууль зүйн Магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.),  
МХХ-НЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ ТЭРГҮҮН



Г.Оюунболд нь криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

Цагдаагийн академид эрх зүйн бакалавр зэрэгтэй төгсөж "Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа" сэдвээр хууль зүйн ухааны магистр зэрэг хамгаалсан. Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Менежментийн бакалаврын зэрэгтэй мэргэжлийн англи хэлний ангид суралцан төгссөн.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.),  
МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ



МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, ҮХ-ийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл туурвил, Эрх зүй улирал тутмын сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцан ажиллаж байв. 2021 оноос МУ-ын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкмений сургуульд Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.